



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ - XII

**БОЛОВСРОЛЫН ТУЛГАМДСАН  
АСУУДАЛ, ШИЙДЭЛ,  
АРГА ЗАМ-2026**

ISSUES AND SOLUTIONS IN EDUCATION



# БОЛОВСРОЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДЭЛ, АРГА ЗАМ

сэдэвт эрдэм шинжилгээний үндэсний  
XII хурлын хураангуйн эмхэтгэл

УЛААНБААТАР ХОТ  
2026 ОН

## ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Т.Ганбаатар	Монгол улсын боловсролын их сургуулийн Математик, байгалийн ухааны сургуулийн захирал
Нарийн бичгийн дарга:	А.Амарзаяа Э.Азжаргал Ц.Амартайван Я.Мөнхсайхан Д.Энхжаргал	МУИС-ийн ШУС-ийн багш, профессор МУБИС-ийн ЭШИ-ийн албаны дарга, дэд профессор МУИС-ийн Ахисан түвшний сургуулийн захирал, профессор МУБИС-ийн МБУС-ийн багш БҮТ-ийн Элсэлтийн шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Лувсандорж Д.Цэдэвсүрэн Л.Мөнхтуяа О.Алтангоо Д.Цолмонтуяа А.Амгалан Д.Энхцэцэг Г.Өлзийсайхан Б.Оюун-Эрдэнэ У.Алимаа А.Амгалан Т.Ганзориг Ч.Нямгэрэл М.Итгэл Д.Түмэнбаяр Ц.Навчаа Б.Алтангэрэл Б.Болдсүрэн Д.Золжаргал Х.Отгонбаатар Б.Буяндэлгэр Б.Лхамцэрэн О.Ирвэс Б.Баярсайхан Б.Лхагвабаяр Г.Гүррагчаа Д.Сумъяа А.Цэнгүүнжаргал Ө.Баяртуяа С.Гэндэнжамц Э.Оюунчимэг Ц.Баярмаа Д.Уранчимэг Л.Нарангарав	МУБИС-ийн МБУС-ийн Дидактикийн тэнхимийн эрхлэгч МУБИС-ийн профессор Сургалт, цахим шилжилтийн хэлтсийн дарга МУБИС-ийн Тамгын газрын дарга, дэд профессор МУБИС-ийн дэд профессор МУБИС-ийн БТС-ийн ахлах багш, доктор МУБИС-ийн БТС-ийн багш, доктор МУБИС-ийн БС-ийн багш, дэд профессор МУБИС-ийн БоСС-ийн ахлах багш, доктор МУБИС-ийн МБУС-ийн ахлах багш, доктор МУБИС-ийн МБУС-ийн багш МУБИС-ийн МБУС-ийн багш МУБИС-ийн МБУС-ийн багш МУИС-ийн ШУС-ийн ахлах багш, дэд профессор МУИС-ийн ШУС-ийн багш, дэд профессор МУИС-ийн ШУС-ийн багш, дэд профессор МУИС-ийн ШУС-ийн дэд профессор МУИС-ийн ШУС-ийн багш МУИС-ийн ШУС-ийн дэд профессор БСҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор БСҮХ-ийн Боловсролын бодлогын судалгааны ЭША, доктор БСҮХ-ийн Боловсролын бодлогын судалгааны ЭША, доктор БСҮХ-ийн Боловсролын бодлогын судалгааны ЭША, доктор БСҮХ-ийн Сургалтын хөтөлбөр, сурах бичгийн судалгааны секторын ЭША БЕГ-ын Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газрын дарга БЕГ-ын Суралцагчийн үнэлгээний хэлтсийн дарга БЕГ-ын Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн БЕГ-ын Дээд боловсролын хөтөлбөр, сургалтын орчин хариуцсан ахлах мэргэжилтэн БЕГ-ын Албан хэрэг хөтлөлт хариуцсан зохион байгуулагч БҮТ-ийн Даалгаврын сангийн хэлтсийн дарга БҮТ-ийн Үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн. ТТИС-ийн ректор, доктор ТТИС-ийн ЭШИ эрхэлсэн проректор, доктор ТТИС-ийн Сургалтын албаны дарга

## "БОЛОВСРОЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДЭЛ АРГА ЗАМ-2026"

### ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

**Хэзээ:** 2026 оны 4 дугаар сарын 17

**Чиглүүлэгч:** Доктор Т.Ганбаатар, МУБИС  
Профессор А.Амарзаяа, МУИС  
Доктор О.Ирвэс, БСҮХ

**Хаана:** Багш хөгжлийн ордон, II давхар 202 тоот

#### НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хугацаа	Үйл ажиллагаа
08 <sup>50</sup> -09 <sup>30</sup>	Бүртгэл
09 <sup>30</sup> -10 <sup>00</sup>	Хурлын нээлт: <ul style="list-style-type: none"> <li>• Урлагийн тоглолт</li> <li>• Мэндчилгээ дэвшүүлж үг хэлэх (БШУЯ, БЕГ, МУБИС, МУИС, БСҮХ, БҮТ, ТТИС)</li> </ul>

#### УРИГДСАН БОЛОН ҮНДСЭН ИЛТГЭЛ

Хугацаа	Илтгэлийн сэдэв	Илтгэгч	
10 <sup>00</sup> -10 <sup>20</sup>	<b>Үндсэн илтгэл 1:</b> Багшийн хөгжлийг сэтгэл ханамжийн судалгаагаар илрүүлэх боломж: ЕБАС-ийн жишээ	Б.Булгамаа, МУИС Ц.Амартайван, профессор МУИС Д.Түмэнбаяр, дэд профессор МУИС	Y1
10 <sup>20</sup> -10 <sup>40</sup>	<b>Үндсэн илтгэл 2:</b> Багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэл дэх сургалтын аргазүйн асуудал (Хувиран өөрчлөгдөх суралцахуй)	О.Алтангоо, дэд профессор МУБИС Х.Батболд, доктор МУБИС Б.Гантуяа, доктор МУБИС	Y2
10 <sup>40</sup> -10 <sup>50</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
10 <sup>50</sup> -11 <sup>20</sup>	<b>Цайны завсарлага</b>		

**Хэзээ:** 2026 оны 04 сарын 17,  
үдээс өмнө  
Багш хөгжлийн ордон, II давхар  
202 тоот

**Чиглүүлэгч:**

Профессор Д.Цэдэвсүрэн, МУБИС  
Профессор А.Амарзаяа, МУИС  
Доктор О.Ирвэс, БСҮХ

Хугацаа	Илтгэлийн сэдэв	Илтгэгч	
11 <sup>20</sup> -11 <sup>40</sup>	<b>Үндсэн илтгэл 3:</b> Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, үр дүн	Б.Алтансүх, БСҮХ	Y3
11 <sup>40</sup> -12 <sup>00</sup>	<b>Үндсэн илтгэл 4:</b> СӨБ, ЕБС-ийн багшийн хөгжлийн чиглэлээр баримталж буй бодлого, хэрэгжилт, анхаарах асуудал	Д.Энхтулга, БЕГ	Y4
12 <sup>00</sup> -12 <sup>20</sup>	<b>Үндсэн илтгэл 5:</b> Боловсролын үнэлгээний өнөөгийн байдал ба хөгжлийн чиг хандлага: Сорилт ба боломж	С.Гэндэнжамц, БҮТ	Y5
12 <sup>20</sup> -12 <sup>40</sup>	<b>Үндсэн илтгэл 6:</b> Багш мэргэжлийн боловсрол сургалтын магистрын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн	Ц.Баярмаа, доктор ТТИС Д.Уранчимэг, доктор ТТИС О.Хулан, доктор ТТИС Б.Очгэрэл, ТТИС	Y6
12 <sup>40</sup> -13 <sup>00</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
<b>Үдийн завсарлага 13<sup>00</sup>-14<sup>00</sup></b>			

## I САЛБАР ХУРАЛДААН

**Хэзээ:** 2026 оны 4 дугаар сарын 17, үдээс хойш

**Хаана:** МУБИС, III-123 тоот

**Чиглүүлэгч:** Профессор Ц.Лувсандорж, МУБИС  
Доктор О.Ирвэс, БСҮХ  
Доктор О.Хулан, ТТИС  
Д.Энхтулга, БЕГ

Хугацаа	Илтгэлийн сэдэв	Илтгэгч	
14 <sup>00</sup> -14 <sup>15</sup>	Монгол улсын дээд боловсролын стратегийн хөгжил ба бодлогын Баримт бичгийн харьцуулсан шинжилгээ (1995–2024)	Ө.Амарзаяа, МУБИС Г.Өлзийсайхан, доктор МУБИС	1.1
14 <sup>15</sup> -14 <sup>30</sup>	Монгол Улсын Боловсролын Тогтолцооны Тогтвортой Байдлын Мониторинг: EWMA Хяналтын Графикт Суурилсан Шинжилгээ (2016–2024)	Г.Баярцэцэг, ШУТИС З.Алтанчимэг, МУИС Б.Шүрэнцэцэг, МУИС Д.Баярмаа, ШУТИС	1.2
14 <sup>30</sup> -14 <sup>45</sup>	Ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг бодлогод тусган хэрэгжүүлэх зарим боломж	Б.Лхагвабаяр, БЕГ Л.Мөнхтуяа, дэд профессор МУБИС С.Батцэцэг, доктор МУБИС	1.3
14 <sup>45</sup> -14 <sup>55</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
14 <sup>55</sup> -15 <sup>10</sup>	Суралцагчийн бүтээлч сэтгэлгээний өөрчлөлт	Ш.Ариунбаяр, БПК	1.4
15 <sup>10</sup> -15 <sup>25</sup>	Reimagining Assessment in Mongolian Education: (Equity, Teacher Stress, and AI-Powered Reform)	П.Амар, Б.Сувдаа, М.Золжаргал	1.5
15 <sup>25</sup> -15 <sup>40</sup>	Суралцахуйн ББЗ цикл: байгууллагын үйл ажиллагааны инвариант бүтэц ба фрактал зохион байгуулалтын онол-аргазүйн үндэс	Д.Батболд, доктор, Сэлбэ ОУС Э.Золбоо, Сэлбэ ОУС Н.Халиун, Сэлбэ ОУС	1.6
15 <sup>40</sup> -15 <sup>50</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
<b>Цайны завсарлага 15<sup>50</sup>-16<sup>10</sup></b>			
16 <sup>10</sup> -16 <sup>25</sup>	Сургуулийн хөгжлийг дэмжих менежментийн нэгэн загвар	Ж.Галбадрах, доктор УИХ	1.7
16 <sup>25</sup> -16 <sup>40</sup>	Аюулгүй байдал, анхны тусламжийн сургалтыг Сайжруулах хэрэгцээ, шаардлага ба үр дүнд суурилсан Арга зүйн ач холбогдол	З.Бямбасүрэн, МУИС	1.8
16 <sup>40</sup> -16 <sup>55</sup>	Академик стресс сурлагын гүйцэтгэлд нөлөөлөх нь: Монголын их, дээд сургуулийн оюутнуудын дундах түгшүүр ба туйлдлын хам шинжийн дараалсан шалтгаант хамаарлын загвар	И.Ундрахгэрэл, Ч.Энхболд, У.Дамдинсүрэн, Ж.Тунгалаг, Д.Баасанхорол	1.9
16 <sup>55</sup> -17 <sup>05</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
17 <sup>05</sup> -17 <sup>20</sup>	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдал, түүнд тулгамдаж буй асуудал (Математикийн багш нарын асуулгын үр дүнгээс)	Б. Эрдэнэчимэг, БСҮХ Ж.Дэнсмаа, БСҮХ	1.10
17 <sup>20</sup> -17 <sup>35</sup>	Ангийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг Оролцоог нэмэгдүүлэх боломж	Э.Төмөрчөдөр, ДПК Б.Ундрах, ДПК	1.11
17 <sup>35</sup> -17 <sup>50</sup>	A Wellbeing Crisis: Evidence from English Language Teachers	М.Даариймаа, дэд профессор МУИС	1.12,
17 <sup>50</sup> -18 <sup>00</sup>	<b>Асуулт, хариулт</b>		

## I САЛБАР ХУРАЛДААН (үргэлжлэл)

**Хэзээ:** 2026 оны 4 дугаар сарын 18, үдээс өмнө  
**Хаана:** МУБИС, III-120 тоот

**Чиглүүлэгч:** Дэд проф, Нямгэрэл МУИС  
 Доктор А.Амгалан, МУБИС

Хугацаа	Илтгэлийн сэдэв	Илтгэгч	
09 <sup>00</sup> -09 <sup>15</sup>	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч-Мэргэжлийн боловсролд	Л.Туул, Э.Бадмаараг	1.12
09 <sup>15</sup> -09 <sup>30</sup>	Хараа-хөдөлгөөний интеграци ба түүнд нөлөөлж буй хүчин зүйлс (Сургуулийн бага ангийн суралцагчдын жишээн дээр)	Э.Баясгалан, БСҮХ Б.Туяа, доктор МУБИС Ч.Байгалмаа, доктор, дэд профессор МУБИС	1.13
09 <sup>30</sup> -09 <sup>45</sup>	Мэргэжил сонголтын чиг хандлагыг холландын онолыг ашиглан тодорхойлсон нь	Н.Далайсайхан, Мандах ИС Д.Түвшинжаргал, Мандах ИС М.Ганхөлөг, Мандах ИС	1.14
09 <sup>45</sup> -09 <sup>55</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
09 <sup>55</sup> -10 <sup>10</sup>	Ахлах ангийн сурагчдын гамшгийн бэлэн байдал, галын аюулгүй байдлын мэдлэг, бэлтгэлд сургалтын үзүүлэх нөлөө (Чингэлтэй дүүргийн жишээн дээр)	Э.Цэнгэл, ОБЕГ	1.15
10 <sup>10</sup> -10 <sup>25</sup>	Сургууль-эцэг эхийн хамтын ажиллагааны гэрээг шинэчлэх замаар оролцоог нэмэгдүүлэх нь	Б.Отгонжаргал, С.Баясгалан, Пүрэвжал, Я.Даваажаргал,	1.16
10 <sup>25</sup> -10 <sup>40</sup>	Дунд ангийн сурагчдын нийгэм- сэтгэлзүйн төлөвшилтөд нөлөөлөх эцэг эхийн оролцоо:	А.Алтангэрэл, Г.Оюунгэрэл, Г.Нандинсүвд	
10 <sup>40</sup> -10 <sup>50</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
<b>Цайны завсарлага 10<sup>50</sup>-11<sup>10</sup></b>			
11 <sup>10</sup> -11 <sup>25</sup>	Ажлын байранд тавигдах шаардлагад залуучуудын мэдлэг, боловсрол, ур чадварын нийцлийн судалгаа	С.Галбадрах, доктор, Удирдлагын Академи	2.13
11 <sup>25</sup> -11 <sup>40</sup>	Боловсролын шинэчлэлд эцэг эхийн үүрэг оролцоо	Б.Бямбасүрэн, М.Сайнжаргал	2.14
11 <sup>40</sup> -11 <sup>55</sup>	Боловсролын шинэчлэлийн хүрээнд эцэг эх сургуулийн хамтын оролцооны туршилтын загвар боловсруулах нь	Ц.Галбадрах, Шинэ санаа ЕБС	2.15
11 <sup>55</sup> -12 <sup>05</sup>	<b>Асуулт, хариулт</b>		

## II САЛБАР ХУРАЛДААН

**Хэзээ:** 2026 оны 4 дугаар сарын 17, үдээс хойш  
**Хаана:** МУБИС, III-120 тоот

**Чиглүүлэгч:** Дэд проф Э.Азжаргал, МУБИС  
 Ц.Лхамсүрэн, БЕГ  
 Доктор, проф Б.Буяндэлгэр, БСҮХ  
 Доктор Я.Мөнхсайхан, МУБИС

Хугацаа	Илтгэлийн сэдэв	Илтгэгч	
14 <sup>00</sup> -14 <sup>15</sup>	Түүхийн хичээлд дүрслэх (визуаль) эх сурвалж хэрэглэх боломж	Б.Дуламжав	2.1
14 <sup>15</sup> -14 <sup>30</sup>	Боловсролын үйлчилгээ ба хүний эрхийн асуудал” (Нийгмийн ухааны хичээлийн жишээн дээр)	А.Алтангэрэл, Г.Оюунгэрэл	2.2

14 <sup>30</sup> -14 <sup>45</sup>	Хиймэл оюуныг ерөнхий боловсролын сургалтад ашиглах талаарх хандлага болон AI нь сурагчдын суралцах чадварт үзүүлэх нөлөө	Т.Тунгалагтамир МУБИС	2.3
14 <sup>45</sup> -14 <sup>55</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
14 <sup>55</sup> -15 <sup>10</sup>	Интеграц суурилсан хичээлийн арга зүй	А.Отгондолгор, Г.Оюунсайхан, МУБИС	2.4
15 <sup>10</sup> -15 <sup>25</sup>	Энерги хангамж сэдвээр STEM хэрэглэгдэхүүн ашиглан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх	Доктор Я.Мөнхсайхан Б.Ариунбаатар С.Энхмандах	2.5
15 <sup>25</sup> -15 <sup>40</sup>	Цэргийн болон хууль сахиулах байгууллагын их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан туршилтад суурилсан физик сургалтын арга	Б.Солонго, ҮБХИС Х.Түвшин-Эрдэнэ, ДХИС Г.Мягмарсүрэн, доктор ҮБХИС	2.6
15 <sup>40</sup> -15 <sup>50</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
<b>Цайны завсарлага 15<sup>50</sup>-16<sup>10</sup></b>			
16 <sup>10</sup> -16 <sup>25</sup>	Оюутан багшийн химийн хэлний кодлох, декодлох чадварын судалгаа	Б.Норовсүрэн, доктор МУБИС	2.7
16 <sup>25</sup> -16 <sup>40</sup>	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын төсөлд суурилсан арга зүй, судалгаа	Б.Даариймаа, Говь-Алтай Б.Жавзандулам, МУБИС	2.8
16 <sup>40</sup> -16 <sup>55</sup>	Цэцэрлэгийн нэгдмэл сургалтын төлөвлөлтөд хийсэн дүн шинжилгээ	Дэд профессор Ц.Наранцэцэг, М.Маралмаа	2.9
16 <sup>55</sup> -17 <sup>05</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
17 <sup>05</sup> -17 <sup>20</sup>	Физикийн е-лаборатори бүтээхэд VR технологи ашиглах нь (Фотоцахилгааны үзэгдлийн жишээн дээр)	Т.Уламбаяр, МУБИС П.Энхцэцэг, ХААИС О.Лхагва, МУИС	2.10
17 <sup>20</sup> -17 <sup>35</sup>	Багшийн хөгжил ба эрүүл мэндийн тулгамдсан асуудал	М.Дашпүрэв, МУИС Т. Дуламрагчаа, МУБИС	2.11
17 <sup>35</sup> -17 <sup>50</sup>	Өсвөр насны хүүхдүүдийн эцэг эхийн хүмүүжүүлэх хэв маяг, үе тэнгийн дээрэлхэлт, сэтгэл хөдлөлийн зохицуулалтын нөлөөг судалсан нь	Э.Ану, Х.Сэндмаа	2.12
17 <sup>50</sup> -18 <sup>00</sup>	<b>Асуулт, хариулт</b>		

### III САЛБАР ХУРАЛДААН

**Хэзээ:** 2026 оны 4 дугаар сарын 18, үдээс өмнө  
**Хаана:** МУБИС, III-123 тоот

Чиглүүлэгч:

Дэд профессор Түмэнбаяр, МУИС  
Доктор Б.Лхамцэрэн, БСҮХ  
Доктор Д.Цолмонтуяа, МУБИС

Хугацаа	Илтгэлийн сэдэв	Илтгэгч	
09 <sup>00</sup> -09 <sup>15</sup>	Бие даан суралцахуйн хүчин зүйлс сурагчдын математикийн амжилтад нөлөөлөх нь: PISA 2022 олон улсын үнэлгээний үр дүнгийн шинжилгээ	Д.Цэцэгдэлгэр, М.Бямбасүрэн, Э.Цэрэнцоодол, БҮТ	3.1
09 <sup>15</sup> -09 <sup>30</sup>	Биологийн элсэлтийн ерөнхий шалгалтын даалгаварын шинжилгээ (2021–2026)	Д.Чинзориг	3.2
09 <sup>30</sup> -09 <sup>45</sup>	“Нийслэлийн 12-р ангийн сурагчдын химийн мэдлэгийн түвшний оношлогоо ба ЭЕШ-д бэлтгэхэд анхаарах агуулгын шинжилгээ”	Ө.Мөнхтуяа, М.Пүрэвдагва, Э.Мэндсайхан	3.3
09 <sup>45</sup> -09 <sup>55</sup>	<b>Асуулт хариулт</b>		







10 <sup>20</sup> -10 <sup>40</sup>	Боловсролын дижиталчилал, хиймэл оюунчиллын тулгамдсан тулгуур 10 асуудал, шийдлийн үндэслэл, эргэцүүлэл <b>Асуулт, хариулт</b>	Профессор Ц.Лувсандорж, Л.Ганцэцэг, Г.Оюунсайхан, У.Алимаа	4.5
10 <sup>40</sup> -11 <sup>00</sup>	Өнөөгийн монголын боловсролын тулгамдсан социал асуудлууд, шийдвэрлэх арга зам <b>Асуулт, хариулт</b>	С.Төмөр-Очир	4.6
11 <sup>00</sup> -11 <sup>20</sup>	Боловсролын шинэчлэлд эцэг эхийн үүрэг оролцоо <b>Асуулт, хариулт</b>	С.Мөнхбат, Б.Баярбаатар	4.7
11 <sup>00</sup> -11 <sup>20</sup>	Боловсролын удирдлагын философи, асуудал, шийдэл <b>Асуулт, хариулт</b>	Н.Пүрэвжав, Б.Батчимэг	4.8
<b>11<sup>20</sup>-11<sup>40</sup> Цайны завсарлага</b>			

### V САЛБАР ХУРАЛДААН (ОЮУТАН)

**Хэзээ:** 2026 оны 4 дугаар сарын 18, үдээс өмнө      **Чиглүүлэгч:** Проф Ц.Амартайван, МУИС  
Доктор Р.Содномцэрэн, БСҮХ  
Ж.Солонго, БЕГ

**Хаана:** МУБИС, III-312 тоот

Хугацаа	Илтгэлийн сэдэв	Илтгэгч	
09 <sup>00</sup> -09 <sup>15</sup>	Харааны бэрхшээлтэй суралцагчтай харилцах математикийн сургалтын арга зүйн чанарын судалгаа	Б.Сэрчмаа Удирдсан: Г.Оюунсайхан	5.1
09 <sup>15</sup> -09 <sup>30</sup>	Сонсголын бэрхшээлтэй сурагчдыг физикийн туршилтаар идэвхижүүлэх нь	Т.Дүүрэнжаргал, Ө.Жавзмаа, Г.Оюунгэрэл, МУБИС, 29 дүгээр сургууль Удирдсан: Я.Мөнхсайхан МУБИС	5.2
09 <sup>30</sup> -09 <sup>45</sup>	Мэргэжлийн боловсролын багшийн үүсгэгч хиймэл оюун ухааны талаарх мэдлэг, чадвар, хандлагыг судалсан судалгаа, үр дүн	П.Отгонжаргал, ТТИС Удирдсан: Л.Нарангарав ТТИС	5.3
09 <sup>45</sup> -09 <sup>55</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
09 <sup>55</sup> -10 <sup>10</sup>	Оюуны бэрхшээлтэй суралцагчийг бодит байдлын үнэлгээнд тулгуурлан суралцагчийг дэмжих, нийгэмд дасан зохицох чадварыг хөгжүүлэх аргазүйн асуудалд	М.Насандулам, ТТИС Удирдсан: Ц.Сумьяа ТТИС	5.4
10 <sup>10</sup> -10 <sup>25</sup>	Химийн хичээлд суралцах сонирхол, хандлагын судалгаа	Д.Лхагвадулам Удирдсан: Б.Норовсүрэн, доктор МУБИС	5.5
10 <sup>25</sup> -10 <sup>40</sup>	Харааны болон хөнгөн хэлбэрийн аутизмын бэрхшээлтэй сурагчдад физикийн хичээлийн туршилтыг үзүүлэх боломж /суурь боловсролын сурагчдын жишээн дээр/	Г.Ганцэцэг Удирдсан: Доктор С.Жамъян МУБИС	5.6
10 <sup>40</sup> -10 <sup>55</sup>	Эцэг эхийн зүгээс сургуулийн үйл ажиллагаанд оролцох байдлыг хэмжих асуулгын монгол хувилбарын найдвартай байдал	Б.Отгонжаргал, О.Саранзул Удирдсан: А.Амарзаяа	5.7
10 <sup>55</sup> -11 <sup>10</sup>	Сурагчдын ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн ээлжит хичээлийг төлөвлөж хэрэгжүүлэх аргазүйн туршилт/Газарзүйн хичээлийн жишээн дээр/	Ш.Мипан, Удирдсан: А.Амгалан	5.8
11 <sup>10</sup> -11 <sup>20</sup>	<b>Асуулт, хариулт</b>		
<b>11<sup>20</sup>-11<sup>40</sup> Цайны завсарлага</b>			

## ГАРЧИГ

МЭНДЧИЛГЭЭ .....	13
ҮНДСЭН ИЛТГЭЛҮҮД .....	18
Багшийн хөгжлийг сэтгэл ханамжийн судалгаагаар илрүүлэх боломж: ЕБАС-ийн жишээ..	18
Багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэл дэх аргазүйн асуудал /Хувиран өөрчлөгдөх суралцахуй/.....	18
Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, үр дүн .....	18
СӨБ,ЕБС-ийн багшийн хөгжлийн чиглэлээр баримталж буй бодлого, хэрэгжилт, анхаарах асуудал.....	19
Боловсролын үнэлгээний өнөөгийн байдал ба хөгжлийн чиг хандлага: Сорилт ба боломж .....	20
Багш мэргэжлийн боловсрол сургалтын магистрын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн .....	20
АМАН ИЛТГЭЛҮҮД.....	21
Монгол улсын дээд боловсролын стратегийн хөгжил ба бодлогын баримт бичгийн харьцуулсан шинжилгээ (1995–2024).....	21
Монгол улсын боловсролын тогтолцооны тогтвортой байдлын мониторинг EWMA Хяналтын Графикт Суурилсан Шинжилгээ (2016–2024) .....	22
Ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг бодлогод тусган хэрэгжүүлэх зарим боломж.....	22
A Wellbeing Crisis: Evidence from English Language Teachers.....	23
Reimagining Assessment in Mongolian Education.....	23
СУРАЛЦАХУЙН ББЗ ЦИКЛ: Байгууллагын үйл ажиллагааны инвариант бүтэц ба фрактал зохион байгуулалтын онол-аргазүйн үндэс.....	23
Академик стресс сурлагын гүйцэтгэлд нөлөөлөх нь: Монголын их, дээд сургуулийн оюутнуудын дундах түгшүүр ба туйлдлын хам шинжийн дараалсан шалтгаант хамаарлын загвар.....	24
Аюулгүй байдал, анхны тусламжийн сургалтыг Сайжруулах хэрэгцээ, шаардлага ба үр дүнд суурилсан Арга зүйн ач холбогдол.....	24
Ажлын байранд тавигдах шаардлагад залуучуудын мэдлэг, Боловсрол, ур чадварын нийцлийн судалгаа.....	25
Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдал, түүнд тулгамдаж буй асуудал (Математикийн багш нарын асуулгын үр дүнгээс).....	25
Ангийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг Оролцоог нэмэгдүүлэх боломж .....	26
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч - Мэргэжлийн боловсролд.....	26
Мэргэжил сонголтын чиг хандлагыг холландын онолыг ашиглан тодорхойлсон нь.....	27

Ахлах ангийн сурагчдын гамшгийн бэлэн байдал, галын аюулгүй байдлын мэдлэг, бэлтгэлд сургалтын үзүүлэх нөлөө (чингэлтэй дүүргийн жишээн дээр) .....	27
<b>СУРГУУЛЬ-ЭЦЭГ ЭХИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭГ ШИНЭЧЛЭХ ЗАМААР ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ</b> .....	<b>28</b>
Дунд ангийн сурагчдын нийгэм- сэтгэлзүйн төлөвшилтөд нөлөөлөх эцэг эхийн оролцоо ..	28
Түүхийн хичээлд дүрслэх (визуаль) эх сурвалж хэрэглэх боломж .....	29
Боловсролын үйлчилгээ ба хүний эрхийн асуудал” /Нийгмийн ухааны хичээлийн жишээн дээр/ .....	29
Хиймэл оюуныг ерөнхий боловсролын сургалтад ашиглах талаарх хандлага болон AI нь сурагчдын суралцах чадварт үзүүлэх нөлөө.....	29
Интеграц суурилсан хичээлийн арга зүй.....	30
Энерги хангамж сэдвээр STEM хэрэглэгдэхүүн ашиглан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх .....	30
Цэргийн болон хууль сахиулах байгууллагын их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан туршилтад суурилсан физик сургалтын арга.....	30
Оюутан багшийн химийн хэлний кодлох, декодлох чадварын судалгаа .....	31
Сургуулийн өмнөх боловсролын сургалтын төсөлд суурилсан арга зүй, судалгаа .....	31
Цэцэрлэгийн нэгдмэл сургалтын төлөвлөлтөд хийсэн дүн шинжилгээ .....	31
Физикийн е-лаборатори бүтээхэд VR технологи ашиглах нь /Фотоцахилгааны үзэгдлийн жишээн дээр/ .....	32
Багшийн хөгжил ба эрүүл мэндийн тулгамдсан асуудал .....	32
Өсвөр насны хүүхдүүдийн эцэг эхийн хүмүүжүүлэх хэв маяг, үе тэнгийн дээрэлхэлт, сэтгэл хөдлөлийн зохицуулалтын нөлөөг судалсан нь .....	33
Сургуулийн хөгжлийг дэмжих менежментийн нэгэн загвар .....	33
Боловсролын шинэчлэлийн хүрээнд эцэг эх сургуулийн хамтын оролцооны туршилтын загвар боловсруулах нь .....	33
Биологийн элсэлтийн шалгалтын даалгаврын шинжилгээ (2021-2025) .....	34
“Нийслэлийн 12-р ангийн сурагчдын химийн мэдлэгийн түвшний оношлогоо ба ЭЕШ-д бэлтгэхэд анхаарах агуулгын шинжилгээ” .....	34
Developing an assessment instrument to measure primary teachers' mathematical knowledge for teaching .....	35
Байгалийн ухааны элсэлтийн шалгалтыг амжилттай өгсөн шалгуулагчдын Их, дээд сургуульд элсэх тэгш боломж.....	35
Төгсөгчдийн ур чадварт чадамжид тулгуурласан сургалт нөлөөлөх нь .....	35
Дээд боловсролын байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийг CSI индексээр тооцох нь .....	36
Их, дээд сургуулийн багшийн сэтгэл ханамжид хийсэн социологийн шинжилгээ .....	36

Ерөнхий хими II хичээлийн явцын шалгалтад давтан хэрэглэгдсэн даалгаврын чанарын гурван улирлын шинжилгээ.....	37
Биеийн тамирын багшийн сургуулийн багийн тамирчдын аэроб чадварын судалгаа.....	37
Бие даан суралцахуйн хүчин зүйлс сурагчдын математикийн амжилтад нөлөөлөх нь: PISA 2022 олон улсын үнэлгээний үр дүнгийн шинжилгээ .....	37
Онлайн сургалтын үнэлгээний рубрикийн хөгжүүлэлт ба баталгаажуулалт .....	38
Цахимд суурилсан мэргэжлийн багш нарын бүлгээр байгууллагын менежментийг хөгжүүлэх нь .....	38
Боловсролын давхраажилт, олон улсын оюутны шилжилт хөдөлгөөн, нийгмийн дахин үйлдвэрлэл: Япон дахь монгол оюутны суралцах замнал.....	39
Их сургуулийн шинэ хичээл бүтээх үйлийн баримжаа,архитектур (“Боловсролын бизнесийн үндэс” хичээлийн жишээн дээр).....	39
Гэр бүлийн цагаар хүүхэдтэйгээ туршилт хийх талаарх судалгааны метадата шинжилсэн үр дүн .....	40
Боловсролын дижиталчилал, хиймэл оюунчиллын тулгамдсан тулгуур 10 асуудал, шийдлийн үндэслэл, эргэцүүлэл .....	40
Өнөөгийн монголын боловсролын тулгамдсан социал асуудлууд, шийдвэрлэх арга зам..	40
Харааны бэрхшээлтэй суралцагчтай харилцах математикийн сургалтын арга зүйн чанарын судалгаа .....	41
Сонсголын бэрхшээлтэй сурагчдыг физикийн туршилтаар идэвхижүүлэх нь.....	41
Мэргэжлийн боловсролын багшийн үүсгэгч хиймэл оюун ухааны талаарх мэдлэг, чадвар, хандлагыг судалсан судалгаа, үр дүн .....	41
Оюуны бэрхшээлтэй суралцагчийг бодит байдлын үнэлгээнд тулгуурлан суралцагчийг дэмжих, нийгэмд дасан зохицох чадварыг хөгжүүлэх аргазүйн асуудалд .....	42
Химийн хичээлд суралцах сонирхол, хандлагын судалгаа .....	42
Харааны болон хөнгөн хэлбэрийн аутизмын бэрхшээлтэй сурагчдад физикийн хичээлийн туршилтыг үзүүлэх боломж /суурь боловсролын сурагчдын жишээн дээр/.....	43
Сурагчдын ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн ээлжит хичээлийг төлөвлөж хэрэгжүүлэх арга зүйн туршилт (Газарзүйн хичээлийн жишээн дээр).....	44
Боловсролын удирдлагын философи, асуудал, шийдэл .....	44

## МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт эрдэмтэн судлаачид, багш сурган хүмүүжүүлэгчид, хурлын төлөөлөгчид өө.

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэхийн ялдамд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тань өндөр амжилт хүсье.

**“Боловсролын тулгамдсан асуудал: Шийдэл, арга зам-2026”** эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдаж байгаа нь салбарын хөгжлийн ирээдүйд нэн чухал ач холбогдолтой юм. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар энэхүү эрдэмтэн мэргэдийн чуулганыг хамтран зохион байгуулж байгаадаа талархалтай байна.

Өнөөдөр бид боловсролын салбарын аливаа сорилт, бэрхшээлийг зөвхөн туршлагаар бус, харин бодит өгөгдөл, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд тулгуурлан шийдвэрлэх зүй ёсны шаардлагатай тулгарч байна. Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах гарц гаргалгааг онолын суурьтайгаар тодорхойлж, хөгжлийн чиг хандлагыг шинжлэх ухаанчаар харахад эрдэмтэн судлаач, багш, оюутан та бүхний бүтээлч оролцоо шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

Өнөөгийн даяаршсан нийгэмд боловсролын шинэчлэлийг шинжлэх ухаанч судалгаатай хослуулж, мэдлэгийн санг тасралтгүй баяжуулах шаардлагатай бөгөөд улмаар судалгааны үр дүнг бодлого боловсруулагч болон хэрэгжүүлэгч нартай нэгдмэл уялдаатайгаар хуваалцах нь салбарын хамтын ажиллагааны чанарын гол үзүүлэлт юм.

Энэхүү хурлаас гарах оновчтой шийдэл, санал, зөвлөмж бүр нь зөвхөн цаасан дээр үлдэх бус, бүх шатны боловсролын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн шатанд бодит ажил хэрэг болох учиртай. Боловсролын ерөнхий газар нь эрдэмтэн судлаачдынхаа гаргасан шинжлэх ухааны үндэслэлтэй санал санаачилга бүрийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэхэд манлайлан ажиллах болно.

Хурлыг хамтран зохион байгуулж буй их, дээд сургуулиуд, мэргэжлийн байгууллагууд болон эрдэм шинжилгээний ажилд чин сэтгэлээ зориулан оролцож буй гадаад, дотоодын нийт судлаачдадаа дахин талархал илэрхийлье.

Та бүхний оюуны мэлмий тунгалаг байж, эрдэм судлалын үйлс тань арвин баян байх болтугай!

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ, БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Т.НЯМ-ОЧИР

## МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт эрдэмтэн судлаачид, бодлого боловсруулагчид, багш сурган хүмүүжүүлэгчид, боловсролын салбарын зүтгэлтнүүд та бүхэнд **“Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл арга зам”** сэдэвт эрдэм шинжилгээний XII хурлын мэндийг өргөн дэвшүүлж, эрдэм мэдлэг, туршлага, санаа бодлоо хуваалцахаар нэгэн дор цугларсанд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Боловсрол бол аливаа улсын тогтвортой хөгжил, хүний хөгжил, нийгмийн хөгжил дэвшлийн суурь хүчин зүйл болдог тул манай улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд боловсролын чанарын төлөөх төлөвлөлт, хэрэгжилт хяналт-шинжилгээ ба үнэлгээ нь өмнөх үеэсээ илүү тодорхой, нийцэлтэй, тогтвортой тусаж хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.

Өнөөдөр бид дэлхий нийтийн дижитал хувьсал, нийгэм–эдийн засгийн хурдтай өөрчлөлт, мэдлэгт суурилсан эдийн засгийн өрсөлдөөнтэй зэрэгцэн боловсролын тогтолцоонд тулгарч буй олон талт сорилтуудтай нүүр тулж байна. Эдгээр сорилт нь зөвхөн асуудал биш, харин шинэчлэл, сайжруулалтын бодит боломж гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Тус хурлаар боловсролын салбарт тулгамдаж буй олон асуудлын шийдлийг хэлэлцэж, чанар, хүртээмж, бодит шийдлийг санал болгоно гэдэгт итгэлтэй байна.

Эрдэм шинжилгээний хурал бол зөвхөн илтгэл хэлэлцэх талбар бус, харин хамтын оюун ухаанаар асуудлыг тодорхойлж, нотолгоонд суурилсан шийдэлд хүрэх бүтээлч орон зай юм. Та бүхний судалгаа, туршлага, шүүмжлэлтэй санал бодол нь боловсролын бодлого, практикт бодитой хувь нэмэр оруулна гэдэгт гүнээ итгэж байна.

Энэхүү хурлын үйл ажиллагаа амжилттай болж, дэлхийн жишиг, олон улсын боловсролын судалгааны чиг хандлагад нийцсэн чанартай, хүртээмжтэй боловсролын тогтолцоог бий болгохын төлөө судалгааны ажлаа хэлэлцүүлж буй эрдэмтэн багш, судлаач шүүмжлэгч, оюутан залуус та бүхэнд талархал илэрхийлж, ажил хөдөлмөр, судалгаа шинжилгээ, эрдэм номын үйлсэд тань амжилт хүсье.

Сайн үйлс бүхэн дэлгэрэн дэвжих болтугай

## МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт багш, судлаач та бүхэндээ үүнийг унших өдрийн мэнд хүргэе. 2014 онд “Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний анхдугаар хурал санаачлан, жил бүр уламжлал болгон зохион байгуулж эхэлснээс хойш хэдийнээ 12 дахь удаагаа болжээ.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлын онцлог нь боловсролын бүх түвшний сургалт, хөтөлбөр, агуулга, арга зүй, үнэлгээ, багшийн хөгжилд тулгамдаж буй асуудал, боловсролын бодлого, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар судалсан, судалгааны ажлын үр дүнг хэлэлцэх, үндэсний хэмжээнд нэгдсэн ойлголцолд хүрэх, бүх түвшний хамтын ажиллагааны уялдаа холбоо, хамтын судалгааг эрчимжүүлэх боломж олгодогт оршдог. Энэ удаагийн хуралд сургуулийн өмнөх, бага боловсрол, ерөнхий боловсролын сургууль, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн оюутан, багш судлаачдын нийт 80 орчим өгүүлэл ирснээс экспертийн уншилтаас шалгуур хангасан 60 орчим өгүүлийг хэлэлцүүлэхээр сонгосон байна. Мөн жил бүр уламжлал болгон хамтран зохион байгуулагч 5 байгууллага болох МУБИС, МУИС, Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн, Боловсролын Үнэлгээний Төв, Боловсролын Ерөнхий газраас тухайн цаг үеийн боловсролын бодлого, асуудал, шийдэл, хийж буй ажлын үр дүн, чиг хандлагыг илэрхийлсэн уригдсан болон үндсэн илтгэлүүд тавигддаг. Энэ удаагийн хурлын зохион байгуулагчаар Техник, Технологийн их сургууль нэмэгдэн орж байна. Эрдэм шинжилгээ бол хамтын ажиллагаанд суурилдаг. Энэ утгаараа үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулахад оролцож, хувь нэмэр болж байгаад зохион байгуулагчдын зүгээс баяртай байна. Боловсролын салбарт шинээр гарч буй судалгааны чиг хандлага, шинэ технологи, арга зүй, тулгарч буй асуудал, бэрхшээл, түүнийг даван гарах боломж, шийдлийн талаар хийсэн судалгааны үр дүнгээ танилцуулахаар энэхүү хурлыг сонгон оролцож буй судлаач, эрдэм шинжилгээний ажилтан, багш, оюутан та бүхэндээ талархаж байгаагаа илэрхийлье.

Энэхүү хурлын хүрээнд яригдсан илтгэл, өгүүллээс, боловсролын тулгамдсан асуудлыг шийдэх олон санаа, үр дүн, бодит үр дүнгүүд гарна гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэндээ эрдэм, бүтээлийн өндөр амжилт хүсэн ерөөе.



## МЭНДЧИЛГЭЭ



Та бүхэнд энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Анх Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Дидактикийн тэнхимийн профессор, багш нарын санаачилгаар боловсролын салбарын таван байгууллага нэгдэн “Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж эхэлсэн нь эдүгээ 12 дахь жилдээ амжилттай үргэлжилж байна.

Энэ хугацаанд бид боловсролын судалгааны олон асуудлыг хэлэлцэн, харилцан туршлага солилцож, хамтран хөгжиж ирсэн билээ.

Хурал тасралтгүй, үр өгөөжтэй зохион байгуулагдаж ирсэнд хамтран ажилласан байгууллага, хамт олон, судлаачид та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хурлын үйл ажиллагааг илүү чанартай, шуурхай зохион байгуулах зорилгоор МУИС-ийн багш нарын санаачилгаар 2023 оноос эхлэн эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах **EasyChair** системийг нэвтрүүлсэн. Үүний үр дүнд өгүүлэл, илтгэл хүлээн авах, ирүүлсэн бүтээлд хөндлөнгийн шүүмжлэгчдийн үнэлгээ хийх боломж бүрдэж, судалгааны бүтээлийн чанар мэдэгдэхүйц сайжирч байна.

Боловсролын асуудал нь зөвхөн их сургуулиудад хамаарах бус, хамтарсан байгууллагууд, суралцагчид, эцэг эх, нийт нийгэмд чухал нөлөөтэй тул судалгааны үнэт бүтээлүүдийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх өргөн боломжийг бүрдүүлж буй энэхүү хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

МУИС-ийн Ректор

Б.Очирхуяг

## МЭНДЧИЛГЭЭ



Хүндэт эрдэмтэн багш, судлаачид, эрхэм зочид төлөөлөгчид, магистрант, докторант оюутнууд аа, Та бүхэнд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын талаар баримтлах бодлогын судалгааг хөгжүүлэх, ололт үр дүнг багшлахуйн ба суралцахуйн үйл, сургалтын чанарыг дээшлүүлэхэд хэрэглэх боломж арга зам, арга зүйг тодорхойлох, үндэсний түвшинд нэгдсэн ойлголцол, зөвшилцлийг бий болгох, үйл ажиллагааг уялдуулах, хамтын судалгааг эрчимжүүлэх зорилгын дор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, арга зам” эрдэм шинжилгээний 12 дугаар хуралд хамтран оролцож байгаадаа туйлын талархалтай байна.

Боловсролын салбарын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэх энэхүү хуралд салбарынхаа дуу хоолой болж мэргэжлийн болон техникийн боловсрол судлал, чиг хандлага, бодлогын хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудлыг хэлэлцэх, гарц боломж шийдлийг хамтдаа тодорхойлоход бид бүгдийн оролцоо хамтын ажиллагаа чухал юм.

Орчин үеийн нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ шаардлагууд нь ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх мэргэжлийн боловсролыг чадамжид суурилсан, судалгаанд тулгуурласан, түншлэлд түшиглэсэн тогтолцоо болгон хөгжүүлэх, багшийн хөгжилд онцгой анхаарахыг шаардаж байна.

Ийм нөхцөлд манай их сургуулийн профессорын баг бодлогоор багш, мэргэжлийн боловсролын магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй нь стратегийн онцгой ач холбогдолтой үйл ажиллагаа гэж үзэж байна.

Энэхүү хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхдээ Монгол Улсын багш бэлтгэдэг томоохон сургуулиудын профессоруудын багийг бүрдүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын багшийн чадамжийн хүрээг тодорхойлон боловсрол судлал, дидактик, судалгааны арга зүйг цөм болгож Их сургууль-үйлдвэрлэлийн түншлэлд тулгуурлах зарчмыг баримтлаж байгаа юм.

Цаашид мэргэжлийн болон техникийн боловсрол судлалын чиглэлээр судалгаанд суурилсан салбарын онцлог болох түншлэлд тулгуурласан багшийн хөгжлийг дэмжих докторын хөтөлбөр хэрэгцээтэй байгааг онцлон тэмдэглэе.

Эрдэм шинжилгээний энэхүү хурал нь зорилгодоо хүрсэн тодорхой гарц шийдэлтэй боловсролын хөгжилд бодит хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Хурлыг хамтран зохион байгуулагч болон судалгаа шинжилгээний ажлаа тууштай хийж, боловсролын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй та бүхэндээ эрдмийн их үйлсэд амжилт хүсье.

*Сайн тогтолцоо сайн багшаас, сайн багш тасралтгүй суралцахаас эхэлдэг.*

*Сайн бүхэн түгэн дэлгэрэх болтугай.*

**Техник технологийн их сургуулийн ректор Ц.Баярмаа**

## ҮНДСЭН ИЛТГЭЛҮҮД

### **Багшийн хөгжлийг сэтгэл ханамжийн судалгаагаар илрүүлэх боломж: ЕБАС-ийн жишээ**

Б.Булгамаа, Ц.Амартайван профессор, Д.Түмэнбаяр дэд профессор  
Монгол Улсын Их Сургууль

**Хураангуй:** Энэхүү судалгаагаар Монгол Улсын нэгэн ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлсэн багшийн мэргэжлийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад сурагчдын зүгээс багш нарын мэргэжлийн чадамжийг хэрхэн үнэлж буйг гурван дараалсан хичээлийн жилд судалсан болно. Судалгаанд 2022–2024 оны хооронд нийт 1,633 сурагч хамрагдсан. Мэдээлэлд SPSS 21 программ ашиглан дүрслэх статистик болон вариацийн шинжилгээ (ANOVA) хийсэн.

Сурагчдын үнэлгээг цогцоор нь авч үзэхийн тулд багшийн мэргэжлийн чадамжийг дараах гурван хэмжээсээр судалсан. Үүнд: хичээлийн төлөвлөлт ба зохион байгуулах чадвар, багш–сурагчийн харилцаа, мөн дэмжихүйц суралцах орчныг бүрдүүлэх чадвар юм.

Дүрслэх статистикийн үр дүнгээс харахад бүх хэмжээсийн дундаж оноо жилээс жилд тогтвортой өссөн байна. Харин вариацийн шинжилгээний үр дүнгээр багш нарын ажлын туршлагын жилүүдийн ялгаанаас хамааран мэргэжлийн чадамжид статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа илрээгүй болно.

Эдгээр үр дүн нь багшийн мэргэжлийн хөгжлийн хөтөлбөрийн өгөөж багш нарын ахмад, залуу байдалд үл хамааран жигд хүртээмжтэй байсныг харуулж байгаа бөгөөд сурагчдын үзэл бодлын үүднээс уг хөтөлбөр багшийн мэргэжлийн чадамжийг үр дүнтэй дэмжсэн болохыг илтгэж байна.

**Түлхүүр үг:** Багшийн хөгжил, суралцагчийн сэтгэл ханамж, заах арга зүй, багш суралцагчийн харилцаа, суралцах орчин

### **Багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэл дэх аргазүйн асуудал /Хувиран өөрчлөгдөх суралцахуй/**

О.Алтангоо, Х.Бөтболд, Б.Гантуяа  
МУБИС, МБУС, Физикийн тэнхим

**Хураангуй:** Энэхүү илтгэл нь багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэл дэх аргазүйн асуудлыг хувиран өөрчлөгдөх суралцахуйн онол болон насанд хүрэгчдийн суралцахуйн хандлагын хүрээнд авч үзсэн болно. Судалгаанд Мезириновын хувиран өөрчлөгдөх суралцахуйн онол, Ноулзын насанд хүрэгчдийн суралцахуйн үзэл баримтлалд тулгуурлан суралцагчийн “үзэл баримтлал, ойлголт”-ын өөрчлөлт, насанд хүрэгчдийн суралцах үйл явцын онцлогийг тайлбарласан.

Илтгэлд хувиран өөрчлөгдөх суралцахуйн загвараар суралцахуйн шаталсан өөрчлөлтийг тодорхойлж, суралцагчийн өмнөх туршлага, ойлголтыг шүүмжлэлтэйгээр эргэцүүлж шинэ мэдлэг, үнэт зүйл, хандлагыг бүтээх үйл явцыг онцолсон. Мөн энэхүү хандлага нь XXI зууны чадварууд болох шүүмжлэлтэй сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх, бие даан суралцах чадварыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй болохыг дүгнэсэн.

### **Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, үр дүн**

Б.Алтансүх, Х.Энхжаргал, С.Отгонтуяа, Б.Оюунцэцэг, М.Ууганзаяа, Д.Пунцагсүрэн  
Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

**Хураангуй:** XXI зууны нийгэм, эдийн засаг, технологийн хурдацтай хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй глобал сорилт, хиймэл оюуны хэрэглээ зэрэг олон хүчин зүйл нь дэлхийн боловсролын чиг хандлагыг тодорхойлох гол үзүүлэлт болж байна. Судлаачдын тэмдэглэснээр,

энэхүү нөхцөл байдал нь ирээдүйн төлөвийг урьдчилан таамаглахад улам бүр хүндрэл учруулж, боловсролын чиг хандлагыг дахин тодорхойлох шинэ шаардлага үүсгэж байна. Хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн ертөнцөд суралцагчийг ирээдүйд бэлтгэх, тулгарч болох сорилтыг даван туулах, олон талт чадамжийг төлөвшүүлэх нь нэн чухал болж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон “Тогтвортой хөгжлийн зорилго-2030” баримт бичигт туссан “хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх” зорилтын хүрээнд эх хэл, түүх, соёл, тусгаар тогтнолоо эрхэмлэн дээдэлж, хүний эрх, эрх чөлөө, олон хэл, соёлын ялгаатай байдлыг хүндэтгэдэг, мэдлэгт суурилсан нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулж, эх дэлхийгээ хамгаалан, асуудлыг шүүн тунгааж бүтээлчээр шийдвэрлэх, ёс суртахуунтай, хариуцлагатай, насан туршдаа суралцах чадвартай иргэнийг төлөвшүүлэхийг чухалчилж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036)”-ыг баталж сургалтын хөтөлбөрийг чадамжид суурилсан хандлагаар шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлээд үе шаттайгаар зохион байгуулж байна. 2025-2026 оны хичээлийн жилд бага боловсролын судлагдахуун бүрийн сургалтын хөтөлбөр, сурагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийг боловсруулж, туршилт судалгааны үр дүнгээр сайжруулах ажлыг хийсэн байна. Туршилт судалгааг нийслэл болон орон нутгийн (аймаг, сум) нийт 27 сургуулийн 1-5 дугаар ангид зохион байгуулсан. Туршилт судалгаа нь шинэчлэн боловсруулсан бага боловсролын сургалтын хөтөлбөр, сурагчийн гарын авлага, дасгал ажлын дэвтрийн тохирцыг бодит сургалтын орчинд туршиж, алдаа оноог дүгнэх замаар үндэсний хэмжээнд нэвтрүүлэхийн өмнөх сайжруулалтыг хийх, чадамжид суурилсан суралцахуйн чиглэлээр багш нарын арга зүйд дэмжлэг үзүүлэхийг зорилго болгов.

Туршилт судалгааны хүрээнд, давхардсан тоогоор 294 багш, 1197 сурагч, 1796 эцэг эх, асран хамгаалагчаас асуулга болон ганцаарчилсан, бүлгийн ярилцлагын аргаар, 637 хичээлд ажиглалт хийж судалгааны мэдээлэл цуглуулж, үр дүнг Word, Excel, SPSS программ ашиглан боловсруулав.

Туршилтын үр дүнд хичээл төлөвлөлтийн биелэлт 64 хувь, багшийн чиглүүлэг 83 хувь, сурагчдын идэвх оролцоо 73 хувь, хөтөлбөрийн тохирц нийцэл нь агуулга, арга зүй, суралцахуйн үйл ажиллагааны хувьд дунджаар 10 онооноос 8.6-8.9-ийн хооронд үнэлэгдсэн нь хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлэх боломж өндөр байгааг харуулж байна.

**Түлхүүр үг:** Сургалтын хөтөлбөр, Бага боловсрол, Суурь чадамж, Тохирц нийцэл, Суралцагчийн дүр төрх.

## **СӨБ,ЕБС-ийн багшийн хөгжлийн чиглэлээр баримталж буй бодлого, хэрэгжилт, анхаарах асуудал**

Д.Энхтулга

Боловсролын ерөнхий газар

**Хураангуй:** Энэхүү илтгэлээр Монгол Улсын хэмжээнд сургуулийн өмнөх (СӨБ) болон ерөнхий боловсролын (ЕБС) сургуульд ажиллаж буй багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын шинэчлэл, түүний үр дүнг авч үзлээ. Боловсролын ерөнхий хууль (2023) болон Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулиар багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих, мэргэжлээ дээшлүүлэх зардлыг төрөөс хариуцах суурь эрх зүйн орчин бүрдсэн.

Судалгааны хүрээнд "Багшийн гурван тулгуурт бодлого" (2024)-ын хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа болон багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинжлэв. Тухайлбал, 2025 онд МДҮС-д 5,536 багш, удирдах ажилтан хамрагдсанаас 78.9% нь амжилттай үнэлэгдэж, bagsh.edu.mn платформоор дамжсан модуль сургалтад нийт 39,846 багш хамрагдаж, арга зүйн дэмжлэг авсан байна. Мөн багш нарын "Мэргэжлийн хөгжлийн бүлэг" (PLC)-ийг үндэсний хэмжээнд дэмжин ажилласнаар хамтын соёл төлөвших, багш ажлын байрандаа бие биеэсээ суралцах тогтолцоо идэвхжсэн байна.

Түүнчлэн олон улсын туршлагаас суралцах "Хүүхдэд ээлтэй-Ментор багш" сургалт, багш солилцооны хөтөлбөрийн хүрээнд дижитал орчин бүрдүүлэх, идэвхтэй сургалтын арга зүйг нэвтрүүлэх сайн туршлагауд бий болж байна. Гэвч багш нарын AI болон интерактив технологийг практикт ашиглах чадварыг сайжруулах, ажлын байрны тасралтгүй хөгжлийг дэмжих сургууль бүхлээрээ ажиллах хандлагыг төлөвшүүлэх шаардлага тулгарсаар байна.

**Түлхүүр үг:** Багшийн хөгжил, модуль сургалт, мэргэжлийн хөгжлийн бүлэг, ментор багш, дижитал шилжилт.

## **Боловсролын үнэлгээний өнөөгийн байдал ба хөгжлийн чиг хандлага: Сорилт ба боломж**

С.Гэндэнжамц

Боловсролын үнэлгээний төв

**Хураангуй:** Энэхүү илтгэл нь боловсролын үнэлгээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, боловсролын үнэлгээний олон улсын хөгжил, чиг хандлагыг тодорхойлон, тулгамдаж буй сорилт, боломжийг тодруулахад чиглэсэн. Боловсролын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг бодитой үнэлэх, сургалтын чанарыг сайжруулах, бодлого боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. Боловсролын үнэлгээ, хэмжилт биднийг зөв зам дээр байгаа эсэхийг хэлж өгдөг үндсэн арга хэрэгсэл болохын хувьд оновчтой, тохирцтой, найдвартай байх ёстой. Сүүлийн жилүүдэд боловсролын үнэлгээ нь зөвхөн мэдлэг шалгах уламжлалт хандлагаас чадвар, хэрэглээ, бүтээлч байдал, шүүн тунгаах зэрэг дээд эрэмбийн сэтгэн бодох чадварыг үнэлэх чиглэлд шилжиж байна. Үүнтэй уялдан үнэлгээний арга зүйд гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, явцын үнэлгээ, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ зэрэг оролцоонд суурилсан хэлбэрүүд сургалтад нэвтэрч байна. Энэхүү илтгэлд 1921 оноос хойш боловсролын үнэлгээнд гарсан өөрчлөлт шинэчлэлтүүд болон одоогийн үнэлгээний тогтолцоо хэрхэн бүрэлдэж байгааг тоймлон шинжилж БҮТ-с жил бүр зохион байгуулдаг Монгол хэл бичгийн шалгалт, Элсэлтийн шалгалт, Багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, Улсын шалгалт гэх зэрэг үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж үзлээ. Орчин үед дижитал технологид суурилсан үнэлгээ, өгөгдөлд тулгуурласан шийдвэр гаргалт нь боловсролын үнэлгээний хөгжлийн гол чиг хандлага болж байна. Гэсэн хэдий ч бодит хэрэгжилтийн түвшинд багш, сургууль өөрийн үнэлгээг хийх үнэлгээний арга зүйн мэдлэг, чадвар харилцан адилгүй ялгаатай, үнэлгээний шударга, ил тод байдлыг хангах асуудлууд тулгамдаж байна. Түүнчлэн үнэлгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэхээс илүү дүн тавих хэрэгсэл байдлаар ашигладаг уламжлалт хандлага хэвээр хадгалагдсаар байна.

Цаашид боловсролын үнэлгээг хөгжүүлэхэд багшийн болон сургуулийн өөрийн үнэлгээний чадавхыг нэмэгдүүлэх, үнэлгээний нэгдмэл бодлого, стандарт, шалгуурыг боловсронгуй болгох, технологид суурилсан үнэлгээний системийг хөгжүүлэх, суралцагч төвтэй, хөгжлийг дэмжих үнэлгээний тогтолцоог төлөвшүүлэх шаардлагатай байна. Мөн үнэлгээний үр дүнг сургалтын чанарыг сайжруулахад бодитой ашиглах, судалгаа, нотолгоонд суурилсан үнэлгээний соёлыг төлөвшүүлэх нь чухал ач холбогдолтой.

**Түлхүүр үг:** Боловсролын үнэлгээ, хэмжилт, бодит байдал, дээд түвшний сэтгэн бодох чадвар, сургалтын чанар

## **Багш мэргэжлийн боловсрол сургалтын магистрын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн**

Ц.Баярмаа<sup>1</sup>, Д.Уранчимэг<sup>1</sup>, О.Хулан<sup>1</sup>, Б.Очгэрэл<sup>1</sup>

<sup>1</sup>Техник технологийн их сургууль

**Хураангуй:** Өнөөгийн мэргэжлийн боловсрол сургалтын салбарын чанар, өрсөлдөх чадвар нь багш нарын тасралтгүй хөгжил, судалгаа шинжилгээний чадамжаас шууд хамаарч байна. Дэлхийн эдийн засгийн тэргүүлэгч орнуудын нэг болох Герман улсын туршлагаас харахад үйлдвэрлэлд суурилсан чадамжийг эзэмшүүлэх чадвартай инженер-багш бэлтгэх нь тогтвортой хөгжлийн чухал хүчин зүйл болдог.

Энэхүү судалгааны зорилго нь ТТИС-ийн хэрэгжүүлж буй UNESCO-ийн загварт суурилсан “Багш, мэргэжлийн боловсрол, сургалт” (E01141101) магистрын хөтөлбөрийн хэрэгжилт, төгсөгчдийн судалгааны ажлын чиг хандлага болон хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг тодорхойлоход оршино. Судалгааг 2025 онд зохион байгуулсан дөрвөн талт фокус бүлгийн хэлэлцүүлэг болон тус хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд хийсэн шинжилгээнд тулгуурлан гүйцэтгэв.

2022–2025 оны хугацаанд тус хөтөлбөрт нийт 153 оюутан элссэнээс 62 нь төгссөн бөгөөд нийт 62 магистрын судалгааны ажил хийгдсэн байна. Судалгааны ажлуудын 40% нь сургалтын агуулга, арга

зүйд, 15% нь хөтөлбөр судлалд, 13.3% нь суралцахуйн үр дүнд, 10% нь үнэлгээнд, 3.3% нь багшийн хөгжилд, 18.3% нь бусад чиглэлд хамаарч байна.

Судалгааны үр дүн нь тус хөтөлбөр нь инженер-багшийн чадамжийг бэхжүүлэх, судалгаанд суурилсан сургалтын орчныг бүрдүүлэх, цаашид докторын хөтөлбөр хөгжүүлэх суурь болох стратегийн ач холбогдолтойг харуулж байна.

**Abstract:** The quality and competitiveness of the Technical and Vocational Education and Training (TVET) sector are increasingly dependent on the continuous professional development and research capacity of teachers. The experience of Germany demonstrates that preparing engineer-teachers capable of delivering competency-based training in real industrial settings is a key driver of sustainable development.

This study aims to examine the implementation of the master's program "Teacher in Technical and Vocational Education and Training" (E01141101), developed based on the framework of UNESCO, and to analyze the trends in graduates' research outputs and labor market relevance. The research is based on a four-stakeholder focus group discussion conducted in 2025 and an analysis of learning outcomes.

Between 2022 and 2025, a total of 153 students were enrolled in the program, of which 60 have graduated. A total of 60 master's theses were completed, with 40% focusing on teaching content and methodology, 15% on curriculum development, 13.3% on learning outcomes, 10% on assessment, 3.3% on teacher development, and 18.3% on other related areas.

The findings indicate that the program plays a significant role in strengthening the capacity of engineer-teachers, fostering a research-based learning environment, and

**Түлхүүр үг:** магистрын хөтөлбөр, МБТБС-ын багш, Мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээ

**Keywords:** master's program, TVET teacher, vocational education, program implementation, evaluation

## АМАН ИЛТГЭЛҮҮД

### Монгол улсын дээд боловсролын стратегийн хөгжил ба бодлогын баримт бичгийн харьцуулсан шинжилгээ (1995–2024)

Ө.Амарзаяа<sup>1</sup>, Г.Өлзийсайхан<sup>1</sup>  
<sup>1</sup>МУБИС

**Хураангуй:** Энэхүү судалгаа нь Монгол Улсын дээд боловсролын хөгжлийн бодлогын чиг хандлагыг 1995–2024 оны хугацаанд батлагдсан бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан шинжлэхэд чиглэв. Судалгааны онолын үндэс болгон их сургуулийн системийг хөгжүүлэх олон улсын түгээмэл гурван стратеги болох сайжруулах (Upgrading), нэгтгэх (Merging), шинээр үүсгэн байгуулах (Creating new) их сургууль байгуулах загваруудыг ашиглав (Salmi, 2009; Altbach & Balán, 2007). Судалгаанд бодлогын баримт бичгийн агуулгын шинжилгээний аргыг хэрэглэж (Bowen, 2009), 1995–2024 оны хугацаанд батлагдсан нийт арван хууль, тогтоол, хөтөлбөр, үзэл баримтлалыг хамруулан үнэлэв. Шинжилгээний үр дүнд Монгол Улсад дээд боловсролын бодлого тасралтгүйгээр одоо байгаа их сургуулиудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сайжруулах стратеги давамгайлж, их сургуулиудыг нэгтгэх бодлого хэсэгчилсэн хэрэгжилттэй үлдсэн бөгөөд шинээр үүсгэн байгуулах стратеги бодит түвшинд хэрэгжээгүй нь тогтоогдов. Энэ үр дүн нь шилжилтийн эдийн засагтай орнуудад дээд боловсролын бодлого ихэвчлэн тогтолцооны бэхжилтэд төвлөрдөг тухай олон улсын судалгаатай нийцэж байна (Hazelkorn, 2011). Судалгааны дүгнэлт нь Монгол Улсын дээд боловсролын бодлогын хэрэгжилтийн онцлог, тогтолцооны бэрхшээл болон ирээдүйн стратегийн боломжийг тодорхойлоход хувь нэмэр оруулна.

**Түлхүүр үг:** дээд боловсролын бодлого, сайжруулах, нэгтгэх, шинээр үүсгэн байгуулах, их сургуулийн засаглал

## Монгол улсын боловсролын тогтолцооны тогтвортой байдлын мониторинг EWMA Хяналтын Графикт Суурилсан Шинжилгээ (2016–2024)

Г.Баярцэцэг, З.Алтанчимэг, Б.Шүрэнцэцэг

**Хураангуй:** Энэхүү судалгаа нь Монгол Улсын боловсролын салбарын мониторингийн тогтолцоог өгөгдөлд суурилсан хандлагаар шинжилж, системийн тогтвортой байдалд нөлөөлөх гол үзүүлэлтүүдийн динамик өөрчлөлтийг илрүүлэх зорилготой. Судалгаанд 2016–2024 оны хугацаанд боловсролын чанар, хүртээмж, тогтвортой байдлыг илэрхийлэх бүлэг дүүргэлт, сурагч–багшийн харьцаа, дээд боловсролд элсэгч эрэгтэй оюутны эзлэх хувь, элсэлтийн ерөнхий шалгалтад байгалийн ухааны бус хичээл сонгосон шалгуулагчдын тоо, багшийн ажлаас гаралт болон багшийн эргэлтийн хувь зэрэг үзүүлэлтүүдийг ашигласан. Арга зүйн хувьд статистик үйл явцын хяналтын (SPC) хүрээнд Exponentially Weighted Moving Average (EWMA) хяналтын графикийг ашиглан хугацааны чиг хандлага, системийн эрсдэлийн дохиог үнэлсэн. Үр дүнгээс харахад бүлэг дүүргэлт болон сурагч–багшийн харьцаа статистикийн ач холбогдолтой өсөх хандлагатай ( $p < 0.05$ ), харин эрэгтэй элсэгчдийн хувь буурах чиг хандлагатай ( $p < 0.01$ ) байна. Мөн 2020 оноос хойш багшийн ажлаас гаралт болон эргэлт огцом нэмэгдсэн нь системийн тогтвортой байдалд сөрөг дохио болж байгааг илэрхийлж байна. Энэхүү судалгаа нь боловсролын мониторингийг уламжлалт тайлбарлах статистикаас давуулан динамик, процесс төвтэй хандлагаар шинжлэх боломжийг харуулж, бодлого боловсруулагчдад эрт үеийн анхааруулах дохио (early warning signals) бүхий шийдвэр гаргалтыг дэмжих практик ач холбогдолтой юм.

**Түлхүүр үг:** Боловсролын тогтолцооны тогтвортой байдал, Хяналт мониторинг, EWMA control chart, үл нийцэл

### Ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг бодлогод тусган хэрэгжүүлэх зарим боломж

Б.Лхагвабаяр<sup>1</sup>, Л.Мөнхтуяа<sup>2</sup>, С.Батцэцэг<sup>3</sup>

**Хураангуй:** Энэхүү судалгааны зорилго нь МУБИС-ийн багш мэргэжлээр төгсөгчдийн ажлын байр дахь гүйцэтгэл, ур чадвар, харилцааны талаар ажил олгогчийн сэтгэл ханамжийг цогц байдлаар тодорхойлж, сургалтын хөтөлбөр, дадлага болон их сургууль төдийгүй салбарын хамтын ажиллагааг сайжруулах бодлого, стратегийн үндэслэлийг гаргахад оршино. Судалгааны арга зүйд SWOT шинжилгээг ашиглан дотоод ба гадаад хүчин зүйлсийг системтэй ангилж, AHP (Analytic Hierarchy Process) аргаар хүчин зүйлсийн жинг тооцоолж стратегийн дөрвөн хувилбар (SO, WO, ST, WT)-ыг эрэмбэлэн үнэлэх интеграл загварыг боловсруулан ашигласан. Судалгааны үр дүнгийн дүнд төгсөгчдийн ажлын байр, ур чадварын зураглал, хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн сургалтын хөтөлбөр зэрэг олон улсын чиг хандлагад суурилсан хөгжлийн чиглэлүүдийг тодорхойлж, сургалтын хөтөлбөр шинэчлэх бодлогын үндэслэлийг бүрдүүлэв. Иймд төгсөгч, ажил олгогч, их сургууль, бодлого тодорхойлогчийн оролцоо бүхий нотолгоонд (өгөгдөлд) суурилсан шийдвэр гаргалтын загвар боловсруулах нь багш бэлтгэх үйл ажиллагааг диплом олголтоос цааших алхам болгож, “education leader” төрүүлэх урт хугацааны хөгжлийн зорилго руу чиглүүлж болох ач холбогдолтойг энэхүү судалгаа харууллаа.

**Түлхүүр үг:** Төгсөгчдийн ажлын байр, SWOT-AHP шинжилгээ, төгсөгчийн чадамж болон ажил олгогчийн шаардлагын уялдааг тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн сургалтын хөтөлбөр, нотолгоонд (өгөгдөлд) суурилсан шийдвэр гаргалтын загвар



## **A Wellbeing Crisis: Evidence from English Language Teachers**

Daariimaa Marav

**Abstract:** Over the past three decades, Mongolia has made significant strides in prioritising English language education as part of its national development agenda. Yet the teachers who carry the weight of this agenda tell complicated stories defined not by professional fulfilment but by exhaustion, isolation, and a growing feeling that the system neither values nor supports them adequately. This paper draws on a synthesis of qualitative findings from three studies of English language teachers working in urban public and private schools and rural contexts. Drawing on the language teacher wellbeing literature, particularly the multi-layered ecological framework which locates wellbeing threats at macro, meso, and micro levels, the paper argues that the teachers face a wellbeing crisis that cannot be attributed to any single factor. At the macro level, expanding English education policy places growing demands on teachers without commensurate investment. At the meso level, unsupportive school culture and dysfunctional collegial relationships erode teachers' professional belonging. At the micro level, excessive workload, resource deprivation, and professional isolation, particularly in rural contexts, undermine daily professional satisfaction. Addressing teacher wellbeing requires coordinated responses across all three levels rather than placing the burden of resilience on individuals.

**Keywords:** teacher wellbeing; EFL teachers; Mongolia; professional development; emotional labour

## **Reimagining Assessment in Mongolian Education**

Amar P., Suvdaa B., Zoljargal M.

**Abstract:** Mongolia's higher education system is undergoing rapid transformation, shaped by the dual imperatives of internationalization and employability. Yet, many students from middle-income herder families, single-parent households, and physically talented scholarship recipients face financial and structural challenges that undermine their academic success. The current university assessment system remains misaligned with the realities of this diverse student population. Furthermore, it is widely believed that students experience heightened stress when term exams begin, but this study also investigates whether teachers themselves worry about their students' performance. This dual perspective highlights the relational pressures of assessment, in which both learners and educators are caught up in the demands of institutional expectations. Drawing on analyses of rising tuition, housing, and food costs in Ulaanbaatar, alongside broader social pressures such as family instability, the paper examines how economic hardship intersects with academic stress to shape student well-being. It situates these challenges within the ethical responsibilities of teachers and institutions, critiquing deficit-based grading frameworks that fail to account for resilience and lived realities. To restore fairness and credibility in education, the paper advocates for an AI-powered assessment tool that enhances transparency and provides flexible exam preparation periods for students facing sensitive circumstances.

**Keywords:** Educational equity, Assessment reform, AI-assisted assessment, Student well-being

## **СУРАЛЦАХУЙН ББЗ ЦИКЛ: Байгууллагын үйл ажиллагааны инвариант бүтэц ба фрактал зохион байгуулалтын онол-аргазүйн үндэс**

Д.БАТБОЛД<sup>1</sup>, Э.ЗОЛБОО<sup>2</sup>

<sup>1,2</sup> Нийслэлийн ерөнхий боловсролын Сэлбэ олон улсын сургууль

**Хураангуй:** Орчин үеийн боловсролын байгууллагын хөгжил нь түүний дотоод зохион байгуулалтын логик, бүтэц, эргэх холбоо бий болгож буй тогтолцооны чанар зэргээс шууд хамаардаг. Энэхүү өгүүлэлд байгууллагын үйл ажиллагаанд үл хувиран хадгалагдах инвариант бүтэц зайлшгүй шаардлагатай болохыг тогтолцооны онолын үүднээс тайлбарлаж, оюуны боловсруулалтын ББЗ циклийг суралцахуйн үйл ажиллагааны инвариант бүтэц болохыг онол – арга зүйн түвшинд үндэслэв. Мөн уг бүтэц нь даалгавар, хичээл, бүлэг сэдэв, байгууллагын менежмент гэх мэт түвшинд давтагдан илэрдэг тул боловсролын байгууллага фрактал зохион байгуулалттай тогтолцоо болон хөгжих

боломжтойг харуулав. Судалгааны үр дүнд ББЗ цикл нь зөвхөн сургалтын аргачлал бус, байгууллагын өөрийгөө хөгжүүлэх дотоод механизм болох боломжтой гэсэн дүгнэлтэд хүрэв.

**Түлхүүр үг:** Инвариант бүтэц, ББЗ цикл, фрактал зохион байгуулалт, тогтолцооны онол, эргэх холбоо, суралцахуйн технологи

### **Академик стресс сурлагын гүйцэтгэлд нөлөөлөх нь: Монголын их, дээд сургуулийн оюутнуудын дундах түгшүүр ба туйлдлын хам шинжийн дараалсан шалтгаант хамаарлын загвар**

И.Ундрахгэрэл, Ч.Энхболд, У.Дамдинсүрэн, Ж.Тунгалаг, Д.Баасанхорол

**Хураангуй:** Энэхүү судалгаа нь Монголын их, дээд сургуулийн оюутнуудын дунд академик стресс, түгшүүр (anxiety), туйлдлын хам шинж (burnout), сурлагын гүйцэтгэлийн (GPA) хоорондын харилцан хамаарлыг шинжилж, ялангуяа түгшүүр болон туйлдлын хам шинжийн хамаарлыг тодорхойлоход чиглэсэн болно. Мөн хүйс нь академик стресс ба түгшүүрийн хоорондын хамааралд зохицуулагчийн нөлөө үзүүлж буй эсэхийг шалгана. COVID-19 цар тахлын үед Монголын хэд хэдэн их, дээд сургуулийн 382 бакалаврын түвшний оюутныг хамруулсан хөндлөн огтлолын судалгааг явуулсан. Судалгаанд баталгаажсан хэмжүүрүүдийг ашигласан бөгөөд үүнд Academic Stress Inventory (ASI), Generalized Anxiety Disorder Scale (GAD-7), Maslach Burnout Inventory–Student Survey (MBI-SS) багтсан. Өгөгдлийг Partial Least Squares Structural Equation Modeling (PLS-SEM) аргаар боловсруулсан. Энэхүү арга нь таамаглалд чиглэсэн шинж чанартай бөгөөд ялангуяа зуучлагчтай нарийн төвөгтэй загварыг шинжлэх, онол хөгжүүлэх, судалгааны эхний шатны нөхцөлд тохиромжтой тул сонгосон (Hair et al., 2022). Хэмжилтийн загварын чанарыг найдвартай байдал (reliability), нэгтгэх хүчинтэй байдал (convergent validity), ялгарах хүчинтэй байдал (discriminant validity; HTMT)-аар үнэлсэн. Харин бүтцийн загварын харилцааг замын коэффициентууд (path coefficients), нөлөөллийн хэмжээ (effect size), мөн таамаглах чадвар (PLSpredict, Q2\_predict)-аар нь үнэлсэн.

**Түлхүүр үг:** Академик стресс; Түгшүүр; Туйлдлын хам шинж; Сурлагын гүйцэтгэл; PLS-SEM; Монгол улс.

### **Аюулгүй байдал, анхны тусламжийн сургалтыг Сайжруулах хэрэгцээ, шаардлага ба үр дүнд суурилсан Арга зүйн ач холбогдол**

З.Бямбасүрэн, МУИС

**Хураангуй:** Сүүлийн жилүүдэд хүүхэд, өсвөр үеийнхний дунд осол гэмтэл, ахуйн болон сургуулийн орчинд тохиолдох аюул эрсдэл нэмэгдэж байгаа нь нийгэм, боловсролын салбарын тулгамдсан асуудлын нэг болж байна. Хүүхдийн осол гэмтлийн шалтгааныг судлахад эрсдэлийг таних чадвар сул, аюулгүй зан төлөв хангалтгүй төлөвшсөн, анхны тусламжийн мэдлэг, ур чадвар дутмаг байдал ажиглагддаг. Ийм нөхцөл байдал нь ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн хүрээнд хэрэгжиж буй “Аюулгүй байдал, анхны тусламж” сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох шаардлагыг бий болгож байна. Энэхүү өгүүлэлд тус сургалтын өнөөгийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, сургалтын үр нөлөөнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлов. Мөн сургалтын арга зүй нь ихэвчлэн онол давамгайлсан, сурагчдын бодит чадвар, зан төлөвийг хангалттай хөгжүүлэхгүй байгааг онцлон авч үзэв. Үүний үндсэн дээр аюулгүй байдал, анхны тусламжийн сургалтыг илүү үр дүнтэй болгохын тулд суралцагчийн идэвхтэй оролцоонд тулгуурласан, мэддэг бус чаддаг болоход чиглэсэн арга зүйг хэрэгжүүлэх шаардлагатайг тодорхойлсон болно.

**Түлхүүр үг:** Аюулгүй байдал, анхны тусламж, сургалтын хэрэгцээ, эрсдэл, боловсрол,

## **Ажлын байранд тавигдах шаардлагад залуучуудын мэдлэг, Боловсрол, ур чадварын нийцлийн судалгаа**

С.Галбадрах, доктор Удирдлагын Академи

**Хураангуй:** Технологийн хурдацтай хөгжил, эдийн засгийн бүтэц өөрчлөгдөхийн хэрээр ажлын байранд шаардагдах ур чадвар тасралтгүй шинэчлэгдэж байгаа боловч залуучуудын боловсролын тогтолцоо тэр бүр энэ өөрчлөлттэй уялдахгүй байх асуудал тулгамдаж байна. Их дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчдийн хувьд ажлын байранд тавигдах шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшсэн байх нь ажлын байртай болох чухал шалгуур байдаг. Хөдөлмөрийн зах зээлд залуучуудын эзэмшсэн мэдлэг, боловсрол, ур чадвар нь ажил олгогчдын шаардлагатай хэрхэн нийцэж байгааг тодорхойлох хэрэгцээнээс үүдэлтэйгээр энэхүү судалгааг гүйцэтгэв. Судалгааг 2 чиглэлээр хийсэн ба залуучуудын ажил хийхгүй байх шалтгааны талаарх судалгаа үндэсний хэмжээний статистик үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэх замаар гүйцэтгэв. Мөн нийслэл ба хөдөө орон нутгийн ажил олгогч ба ажил эрхлэгч залуучуудаас авсан санал асуулга авч үнэлэлт дүгнэлт өгөв. Судалгааны үр дүнгээс үзэхэд манай улсын өнөөгийн нөхцөлд ажлын байранд тавигдах шаардлагад залуучуудын мэдлэг, боловсрол, ур чадварын нийцэл харилцан адилгүй байгаа нь тогтоогдов.

**Түлхүүр үг:** Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, боловсролын чанар, мэргэжилтэнд тавигдах шаардлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт

## **Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдал, түүнд тулгамдаж буй асуудал (Математикийн багш нарын асуулгын үр дүнгээс)**

Б.Эрдэнэчимэг, Ж.Дэнсмаа

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

**Хураангуй:** Манай улс “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэл”-ийн бодлогын хүрээнд боловсруулсан суурь боловсролын математикийн сургалтын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд 2015-2016 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлснээс хойш 10 жилийн хугацаа өнгөрөөд байна. 2018 онд сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах цогц үйл ажиллагааг төлөвлөгөөтэй, зохион байгуулалттай, тасралтгүй дэмжин ажиллах хөтөлбөрийн менежментийн циклийг 10 жилийн хугацаатай байхаар шийдвэрлэсэн. Улмаар сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг судлах, судалгаанд үндэслэн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийн явцад сургалтын хөтөлбөрийг үнэлэх ажлыг тасралгүй хийж, дараагийн шинэчлэлд бэлтгэж байх хэрэгцээг бий болгосон.

2024 онд МУЗГ-ын 176 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-ыг баталж, түүнд нийцсэн сургалтын хөтөлбөрийг түвшин бүрээр боловсруулах ажлыг хийж эхэлсэн байна. Энэ хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилээс сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, 2025-2026 оны хичээлийн жилээс суурь боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулах ажлыг төлөвлөн ажиллаж байна.

Иймд одоо хэрэгжиж суурь боловсролын математикийн сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх багш нарын санаа бодлыг тандах зорилгоор асуулга судалгаа авсан. Нийслэл болон орон нутгийн 770 гаруй математикийн багш хамрагдсан энэхүү судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулсан холимог судалгааны дизайныг хэрэглэсэн. Судалгаанд хамрагдсан 720 гаруй математикийн багшийн хариулт дахь тоон мэдээлэлд MS-Excel, SPSS 27.0 программ ашиглан дескриптив шинжилгээг, чанарын мэдээлэлд сэдэвчилсэн шинжилгээг (thematic analysis) хийсэн. Математикийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг багш нарын 9.4% 5 оноогоор, 36.7% 4 оноогоор, 45.3% 3 оноогоор, 6.4% 2 оноогоор, 2.2% 1 оноогоор тус тус үнэлсэн бөгөөд тэд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд 1. сургалтын хөтөлбөрийн тухайд: математикийн сургалтын хөтөлбөрийн агуулга их, судлах цагтаа багтдаггүй, анги бүр дэх агуулгын өргөсөл, гүнзгийрэл тодорхой бус, ижил агуулгыг анги бүрд давтан судалж буй нь цагийн төлөвлөлтөд сөргөөр нөлөөдөг, 2. сурах бичгийн

тухайд: сурах бичгийн сэдвийн тоо олон, нэг сэдвээр бататгах дасгал, даалгаврын тоо цөөн, жишээ, тайлбар бага, ялгаатай түвшний даалгавар цөөн гэх мэт бэрхшээлүүдийг дурдаж байна. Цаашид сургалтын хөтөлбөрийг сайжруулахын тулд багш нар боловсролын түвшин, анги бүрийн агуулгын залгамж холбоог сайжруулах, анги бүрд давтагдах агуулгын өргөсөл, гүнзгийрлийг оновчтой тодорхойлох, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болдог сурах бичгийг сайжруулж, бататгах болон ялгаатай түвшний даалгаврыг сурах бичигт тусгах зэрэг саналуудыг гаргасан байна.

**Түлхүүр үг:** Сургалтын хөтөлбөр, математикийн багш, сурах бичиг, суурь боловсрол, агуулга

### **Ангийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг Оролцоог нэмэгдүүлэх боломж**

Э.Төмөрчөдөр, Б.Ундрах, ДПК

**Хураангуй:** Энэхүү судалгааны ажил нь ангийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх боломжийг Дорнод аймаг дахь Политехник коллежийн жишээн дээр судлахад чиглэсэн болно. Судалгааны зорилго нь эцэг эхийн хурлын өнөөгийн байдал, оролцооны түвшин, тулгамдсан асуудлыг тодорхойлон, багш-эцэг эх-суралцагч гурван талын хамтын ажиллагааг сайжруулах арга замыг тодорхойлоход оршино. Судалгаанд багш (n=51), эцэг эх (n=390), суралцагч (n=407) нийт 848 оролцогч хамрагдсан бөгөөд Likert-ийн 5 шатлалт асуулга, корреляци болон регрессийн шинжилгээний аргуудыг ашигласан. Судалгааны үр дүнгээс харахад эцэг эхийн оролцоо нь суралцагчийн урам зориг, сурлагын амжилтад эерэг нөлөөтэй ( $r \approx 0.50$ ,  $p < 0.001$ ) болох нь тогтоогдсон. Харин эцэг эхийн хурлын бодит ирц харьцангуй доогуур байгаа нь (багшийн үнэлгээгээр 41.2%) оролцоонд саад болж буй хүчин зүйлс нь цаг зав, мэдээллийн хүртээмж, зохион байгуулалтын хэлбэртэй холбоотойг харуулсан. Мөн судалгаагаар оролцооны тооноос илүү чанар чухал болох нь батлагдсан бөгөөд эцэг эхтэй тогтмол харилцах, хамтран шийдвэр гаргах, суралцагч төвтэй хурал зохион байгуулах нь илүү үр дүнтэй гэж дүгнэгдсэн. Туршилтын ажлын хүрээнд суралцагч төвтэй, уян хатан харилцаанд суурилсан ангийн хурлыг хэрэгжүүлснээр суралцагчдын идэвх, хичээлд оролцоо, эцэг эхийн дэмжлэг нэмэгдсэн эерэг үр дүн гарсан. Иймээс ангийн эцэг эхийн хурлыг уламжлалт мэдээлэл дамжуулах хэлбэрээс татгалзаж, гурван талын идэвхтэй оролцоонд суурилсан, суралцагчийн хөгжилд чиглэсэн загварт шилжүүлэх нь боловсролын чанарыг дээшлүүлэх чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

### **Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч - Мэргэжлийн боловсролд**

Л.Туул, Э.Бадмаараг

**Хураангуй:** Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг /цаашид ХБХ гэх/ мэргэжлийн сургуульд хамруулан сургах боломжийг хангахын тулд дэлхий нийтээрээ болон Монгол улс томоохон бодлого зохицуулалтыг хийсээр л байна. Гэсэн хэдий ч ХБХ-ийг тэгш хамруулах боловсролын талаар мэргэжилтнүүд, багш нар, эцэг эхчүүд, ажил олгогч нарын ойлголтын зөрүүтэй байдлаас шалтгаалан тэдэнд мэргэжил олгох, мэргэжлийн түвшин тогтоох улмаар ажлын байранд зуучилах, ажлын байраар хангах зэрэг эрх зүйн зохицуулалтууд ямагт туламдаж буй асуудлууд болсоор байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад мэргэжлийн боловсрол олгох, чадамжтай мэргэжилтэн бэлтгэх явцад гардаг тулгамдаж буй асуудлыг олж илрүүлэх, улмаар шийдвэр гаргах түвшний хуулийн этгээдэд мэдээллэж шийдвэрлэх арга замыг гаргуулах мөн ЧСС-ын үнэлгээнд ХБС-дад зориулсан улсын бодлого зохицуулалт цогцоороо хэрэгтэй байна.

**Түлхүүр үг:** Хөгжлийн бэрхшээлтэй хүн, мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөр, чадамжийн үнэлгээ

## **Мэргэжил сонголтын чиг хандлагыг холландын онолыг ашиглан тодорхойлсон нь**

Н.Далайсайхан, МандахИС Д.Түвшинжаргал, МандахИС М.Ганхөлөг, МандахИС

**Хураангуй:** Мэргэжил сонголт нь хүний ирээдүйн амьдрал, нийгмийн байр суурь, амжилтанд шууд нөлөөлдөг чухал шийдвэрийн нэг юм. Манай орны хувьд ахлах ангийн суралцагсдад мэргэжил сонголт, түүний чиг баримжааг учир дутагдалтай олгож байгаагаас нийгмийн хөгжлийн цаашдын хандлагад ч сөргөөр нөлөөлж байна. Мэргэжил сонголтоо буруу хийх нь хувь хүн талаасаа сэтгэл ханамжгүй байдал, сургуулиа орхин хугацаа алдах, ажил мэргэжилдээ дургүй, мэргэжлээрээ ажиллахгүй, мэргэжлээрээ ажилласан ч карьер өсөхгүй байх, харин нийгэм талаасаа хүний нөөцийн тэнцвэргүй байдал үүсгэх, ажилгүйдэл нэмэгдэх, эдийн засгийн үр ашиг буурах, ажлын байрны тогтворгүй байдал, хүний нөөцийн эргэлт нэмэгдэх, боловсролын системд итгэх итгэл буурах гэх мэт сөрөг нөлөөллийг нэмэгдүүлж байна. Энэхүү илтгэлээр мэргэжил сонголтын чиг хандлагыг Жон Л. Холландын мэргэжил сонголтын онол (RIASEC Theory)-д тулгуурлан гаргасан ба судалгаанд оролцогчдийн 57.8% нь өөрийн мэргэжлийн хэв шинждээ тохирсон мэргэжлээ сонгож суралцаж байгаа ба 42.2% нь өөрт тохирсон мэргэжлээ сонгоогүй нь харагдлаа. Хөтөлбөрөөр нь авч үзвэл, нягтлан бодох бүртгэл хөтөлбөрийн хувьд хэв шинж тохирсон байдал нь 76.9%-тай, банк санхүүгийн хөтөлбөрийн хувьд 57.3%-тай боловч программ хангамж, мэдээллийн систем хөтөлбөрөөр суралцагсдын хэв шинж тохирсон байдал 31.7% байгаа нь судалгаанд оролцогчдын дийлэнх хувийг тохирсон хэв шинжтэй нийцэхгүй байгааг харуулж байна. Хүн мэргэжлийнхээ онцлогт тохирсон ажил, мэргэжлийг сонгон эзэмшсэн тохиолдолд амжилтанд хүрч, тухайн ажил, мэргэжилдээ сэтгэл хангалуун байдаг.

**Түлхүүр үг:** Мэргэжил, Сонирхол, Хэв шинж, Хандлага, Үнэлэмж, Карьер

## **Ахлах ангийн сурагчдын гамшгийн бэлэн байдал, галын аюулгүй байдлын мэдлэг, бэлтгэлд сургалтын үзүүлэх нөлөө (чингэлтэй дүүргийн жишээн дээр)**

Э.Цэнгэл, ОБЕГ

**Хураангуй:** Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн ахлах ангийн (11–12-р анги) сурагчдын гамшгийн бэлэн байдал болон галын аюулгүй байдлын мэдлэг, зан үйлийн бэлтгэлд сургалтын арга хэмжээ үзүүлэх нөлөөллийг статистикийн аргаар үнэлэхэд чиглэгдсэн. Хагас туршилтын (quasi-experimental) загварт тулгуурласан судалгаанд сургалтаас өмнөх шатанд 180, давтан хэмжилтэнд санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгогдсон 80 сурагч хамрагдсан. Мэдлэг болон зан үйлийн бэлтгэлийн 9 үзүүлэлтийг бүтэцлэгдсэн асуулгаархэмжиж, үл хамааралт хоёр түүврийн т-тестээр (independent samples t-test, IBM SPSS 26) боловсруулсан. Судалгааны үр дүнд нийт 9 үзүүлэлтийн 8-д нь статистикийн ач холбогдол бүхий эерэг өөрчлөлт ( $p < 0.05$ ) илэрч, нийт дундаж үзүүлэлт 51.9%-аас 71.3% болж 19.4 пунктээр нэмэгдсэн байна. Хамгийн мэдэгдэхүйц өсөлт нь бэлтгэл багцын мэдлэг (+37.4 пп), бэлэн байдлын өрхийн төлөвлөгөө (+30.6 пп), уулзах газрын хэлэлцээ (+30.4 пп) зэрэг бэлтгэлийн үзүүлэлтүүдэд ажиглагдсан бөгөөд эдгээр нь  $p < 0.001$  түвшинд нотлогдсон. Харин гамшигт өртсөн туршлагын үзүүлэлт ( $\Delta = +0.4$  пп,  $p = 0.465$ ) сургалтын нөлөөнд мэдэгдэхүйц өөрчлөлт үзүүлээгүй нь уг хэмжүүр нь сургалтаар хяналт тавих боломжгүй, орчны хүчин зүйлсээс хамааралтайг харуулж байна. Судалгааны дүгнэлт нь аюулгүй байдлын сургалт мэдлэг болон анхдагч бэлтгэлийг нэмэгдүүлэхэд тодорхой үр нөлөөтэй боловч зан үйлийн урт хугацааны тогтвортой өөрчлөлтийг бий болгохын тулд давтамжтай, оролцоонд суурилсан, системтэй арга хэмжээ зайлшгүй шаардлагатайг нотолж байна.

**Түлхүүр үг:** гамшгийн бэлэн байдал, галын аюулгүй байдал, аюулгүй, амьдрах ухаан, сургалт, сурагч

## СУРГУУЛЬ-ЭЦЭГ ЭХИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭГ ШИНЭЧЛЭХ ЗАМААР ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Б.Отгонжаргал, С.Баясгалан, Я.Даваажаргал

**Хураангуй:** Үндэслэл ба хэрэгцээ шаардлага Deming (1986) байгууллагын ажил үр нөлөөтэй байх нь “төлөвлөлт–хэрэгжилт–үнэлгээ–сайжруулалт гэсэн дараалал тасалдахгүй байх”-аас хамаарна гэж тодорхойлсон нь манай судалгаанд илэрсэн хариуцлагын механизмгүй, үнэлгээний шат дутуу гэрээний доголдлыг бүрэн тайлбарлаж байна. Мөн Жойс.Л.Эпстэйн (2011) “хамтын оролцоо нь эрх, үүргийн тэнцвэртэй бүтэц дээр тогтох ёстой” гэж үздэг нь төрийн сургуулийн гэрээ зөвхөн эцэг эхийн үүргийг давуулсан, оролцооны тэнцвэр алдагдсан гэдэг судалгааны дүгнэлтийг нотолж байна. Ерөнхий боловсролын сургуулийн эцэг эх, асран хамгаалагчтай хийх хамтын ажиллагааны гэрээний загварыг 2023 онд БЕГ-ын даргын А№276 тушаалын хавсралтаар баталсан байдаг.Төрийн ба хувийн хэвшлийн бүх сургуулиуд уг загварт баримжаалан гэрээгээ боловсруулдаг боловч манай сургуулийн хувьд гэрээний ач холбогдол, үр нөлөө бага байгаа хомсдол ажиглагдсан. Төрийн ба хувийн өмчийн гурван сургуулийн гэрээнд харьцуулсан баримтын судалгааг хийж үзэхэд төрийн өмчийн сургуулиудын гэрээ өрөөсгөл байгааг илрүүлсэн. Иймээс хуульчид хандан гэрээний загварт мэргэжилийн дүгнэлт гаргуулахад “Одоогийн загвар нь хариуцлага тооцох бодит механизмгүй, ерөнхий хуулийн заалтад тулгуурласан “хэлбэр төдий” байгаа нь түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шинэчлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна” гэсэн дүгнэлтийг гаргасан юм.

**Түлхүүр үг:** боловсролын шинэчлэл, эцэг эхийн оролцоо, хамтын хариуцлага, хүүхэд хамгаалал, гэрээ

### Дунд ангийн сурагчдын нийгэм- сэтгэлзүйн төлөвшилтөд нөлөөлөх эцэг эхийн оролцоо

А.Алтангэрэл, Г.Оюунгэрэл, Г.Нандинсүвд

**Хураангуй:** Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандалга, орчин үеийн хэрэгцээнд нийцсэн иргэдийг төлөвшүүлж нийгэмд бэлтгэхийн тулд бидний зүгээс олон төрлийн ур чадвар, хэрэгцээ шаардлагатай байгаа энэ үед хамгийн чухал нь боловсролд баримтлах зарчим, багшлахуйн чадвар, сурагчдын хэрэгцээ сонирхолд нийцсэн хөтөлбөр, технологи, инновацид суурилсан шинэчлэл хамгийн чухал. Орчин үеийн хэрэгцээнд нийцсэн боловсролыг сурагчдад эзэмшүүлж, тэднийг хөгжүүлэхэд ямар тулгамдаж буй асуудал байгааг тодорхойлж, арга замыг эрэлхийлэх нь энэхүү судалгааны ажлын гол мөн чанар юм. Боловсролын шинэчлэл ямар байх ёстой вэ? гэсэн асуултын хариултыг хайж байгаа энэ үед сурагчдад насан туршдаа суралцдаг байх хэрэгцээ, шаардлага чухлаар тавигдаж байна. Шинэ эрэлт, чиг хандлага нь тодорхой бус нөхцөл байдлыг даван туулахын тулд Нэгдүгээрт. Өнөөгийн суралцагчдад өөрсдийн ертөнцийг бүтээх хөгжүүлэхэд ямар мэдлэг, чадвар, хандлага зан үйл үнэт зүйл хэрэгтэй болох вэ? Хоёрдугаарт. Сургалтын тогтолцоо тэдгээрийг хэрхэн эзэмшүүлж үр дүнтэй хөгжүүлэх вэ? Гуравдугаарт. Эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо ямар түвшинд байна вэ? Гэдэгт тулгуурлан энэхүү судалгаат аргагүйн илтгэлээ бичсэн. Боловсролын систем нь тодорхой үе шатуудтай явагддаг. Нэг үеэс нөгөө үерүү шилжих явцад сурагчдын нийгэмшил, төлөвшил, хандалгат гарах өөрчлөлтөд тулгуурлан дараа дараагийн үйл ажиллагааг төлөвлөх нь хамгийн чухал. Боловсролын эцсийн зорилго нь нийгэмд дасан зохицдог, харилцааны ур чадвартай, бүтээлч тасралтгүй суралцдаг, асуудлыг шийдвэрлэх чадвартай иргэнийг бүтээх юм.

**Түлхүүр үг:** VUCA, SPSS ,бага ангиас дунд анги руу шилжих үеийн сурагч, эцэг эх, хүүхдийн сэтгэлзүй, Хамтын ажиллагаа, Нийгэмшилд, Гэр бүлийн гишүүдийн дэмжлэг, Анги удирдсан багш

## Түүхийн хичээлд дүрслэх (визуаль) эх сурвалж хэрэглэх боломж

Б.Дуламжав

**Хураангуй:** Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт шавь төвт, идэвхтэй суралцах арга зүйг төлөвшүүлэх, сургалтын агуулга, арга хэлбэрийг орчин үеийн нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэх асуудал онцгой ач холбогдолтой болж байна. Ялангуяа түүхийн хичээлийн хувьд сурагчдын өнгөрсөн үйл явцыг бодитойгоор төсөөлөх, шалтгаан үр дагаврын холбоог ойлгох, нэгтгэн дүгнэх, үнэлэх чадварыг хөгжүүлэхэд сургалтын хэрэглэгдэхүүн, эх сурвалжийн сонголт, тэдгээрийг ашиглах арга зүй чухал нөлөө үзүүлдэг. Түүхийн сургалтад уламжлалт бичгийн сурвалжийг давамгайлан хэрэглэж ирсэн хэдий ч орчин үеийн боловсролын онол, практикт дүрслэх (визуаль) эх сурвалжийг сургалтад үр дүнтэй ашиглах боломж, хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Зураг, гэрэл зураг, зурагт хуудас, газрын зураг, бүдүүвч, инфографик, кино, баримтат бичлэг зэрэг дүрслэх эх сурвалж нь сурагчдын анхаарлыг татах, ойлголтыг тодорхой болгох, мэдээллийг цогцоор нь хүлээн авах, ой тогтоолтыг сайжруулах давуу талтай. Гэвч ерөнхий боловсролын сургуулийн түүхийн хичээлд дүрслэх эх сурвалжийг оновчтой ашиглах арга зүй төдийлөн боловсронгуй бус, дүрслэх эх сурвалжийн хэрэглээ жигд бус, ялгаатай түвшинд байна. Энэ нь дүрслэх эх сурвалжийг сургалтын зорилттой уялдуулан системтэй хэрэглэх арга зүйг цогцоор нь боловсруулах шаардлагатайг харуулж байна. Иймээс дээрх асуудлын хүрээнд дүрслэх эх сурвалжийг хэрэглэх онол, арга зүйн үндэс, боловсрол дахь практик хэрэглээ, тэдгээрийн танин мэдэхүйн үр өгөөжийг судлан, шинжлэхийг зорьсон юм.

### Боловсролын үйлчилгээ ба хүний эрхийн асуудал” /Нийгмийн ухааны хичээлийн жишээн дээр/

А.Алтангэрэл, Г.Оюунгэрэл

**Хураангуй:** Дэлхий нийтийн жишигт нийцсэн боловсролыг хүртээмжтэй хэрэглэхийн тулд цахим технологид суурилсан хиймэл оюун ухааныг (AI) ашиглах хэрэгцээ үүссэн. Цахим технологийн шинэчлэлд суурилсан.

### Хиймэл оюуныг ерөнхий боловсролын сургалтад ашиглах талаарх хандлага болон AI нь сурагчдын суралцах чадварт үзүүлэх нөлөө

Т.Тунгалагтамир МУБИС

**Хураангуй:** Боловсролын салбарт хиймэл оюун ухааны хэрэгслүүдийг ашиглах нь хүүхдийн суралцах үйл явц болон хөгжлийг дэмжих зорилготойгоор улам бүр нэмэгдэж байна. Эн Жи нарын судлаачид “Сүүлийн үед насны онцлогт тохирсон хиймэл оюун ухаанд суурилсан технологи, хэрэгслүүд гарч ирсэн нь K–12 контекстэд хиймэл оюун ухааны боловсролыг нэвтрүүлэхэд хүргэсэн” (Ng, Leung, Chu, & Qiao, 2021), гэж үзсэн. Манай орны боловсролын салбарт ч энэ асуудлыг тодорхой хэмжээнд авч үзэх хэрэгцээ шаардлага гарч байна. Үүнтэй уялдуулан

1. Дэлхий нийтэд хиймэл оюуныг ерөнхий боловсролд нэвтрүүлэх талаарх чиг хандлага ямар байна вэ?

2. Хиймэл оюуны ерөнхий боловсролд хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх вэ? гэсэн асуултыг дэвшүүлж хиймэл оюун ухааныг ерөнхий боловсролын сургалтад нэвтрүүлэх талаарх багш, мэргэжилтнүүдийн үзэл бодол, хандлагыг судлах зорилгоор Googleforms ашиглан асуулга авч SPSS дээр боловсруулалт хийж үр дүнг шинжилсэн. Үүний үр дүнд хиймэл оюуны хэрэглээний боловсролыг сурагчдын бүтээлч, шүүмжлэлт, бие даасан сэтгэлгээнд эерэгээр нөлөөлөх хэлбэрээр төлөвлөх зэрэг ажлыг хийх шаардлагатай болохыг боловсролын салбарын бодлого боловсруулагчдад санал болгож байна.

**Түлхүүр үг:** Ерөнхий боловсролын сургууль, Суралцагч, Хиймэл оюун



## Интеграц суурилсан хичээлийн арга зүй

А.Отгондолгор, Г.Оюунсайхан, МУБИС

**Хураангуй:** Өвөрхангай аймгийн Хархорин сумын Ерөнхий боловсролын Орхон сургуулийн XI ангийн 3 бүлгээс “Тэгшитгэлийн систем” бүлэг сэдвийн үнэлгээг хийхэд “ Хоёр хувьсагчтай шугаман тэгшитгэлийн систем”-ийг нэмэх болон орлуулах аргаар бодох даалгаврын гүйцэтгэлийн хувь хангалтгүй шалгагдсан. Бүрэн дунд боловсролын математикийн хичээлийн цаг бага /заавал судлах агуулга 3 цаг буюу 120 минут/, үзэх агуулга их байдгаас тухайн хичээлийг бататгах, давтах цаг гардаггүй. Тиймээс агуулга хоорондын интеграци хичээлээр өмнөх агуулгыг шинэ хичээлийн агуулгатай холбон аргазүйн сайжруулалтыг хийж ажиллах хэрэгцээ зайлшгүй үүсэж байгаа юм. Интеграци хичээл гэдгийг багш нар хичээл хоорондын уялдаа холбоогоор түлхүү авч үздэг. Энэ судалгааны ажлаараа математикийн хичээлийн агуулга хоорондын интеграци хичээлийг зохион байгуулснаар багшийн заах арга зүй болон сурагчдын мэдлэг чадварт хэрхэн ахиц гарахыг судлахыг зорьсон.

**Түлхүүр үг:** Интеграци хичээл, агуулга хоорондын уялдаа холбоо, бүлэг сэдэв, үр дүн, арга зүй,

## Энерги хангамж сэдвээр STEM хэрэглэгдэхүүн ашиглан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх

Я.Мөнхсайхан Б.Ариунбаатар С.Энхмандах

**Хураангуй:** Энэхүү судалгаа нь ЕБС-ийн 6-р ангийн сурагчдын бүтээлч сэтгэлгээг STEM (STEM) сургалтын хэрэглэгдэхүүн ашиглан хөгжүүлэх боломжийг судалсан болно. Физикийн хичээлд "Энерги" сэдвийн хүрээнд "Алхам алхмаар бие даах" аргазүйг ашиглан явуулсан туршилт хичээлийн үр дүнд суралцагчдын бүтээлч сэтгэлгээний ерөнхий дундаж оноо статистик ач холбогдол бүхий ( $p < .001$ ) түвшинд ахисан үр дүн үзүүлэв. Бүтээлч сэтгэлгээний ерөнхий дундаж оноо туршилтын өмнөх үеэс ахисан бөгөөд дундаж онооны ялгаа нь 0.27, 95% итгэлцлийн интервалд [0.15, 0.39],  $p < 0.001$  байна. Судалгаанд хамрагдсан туршилтын ба хяналтын бүлгийн бүтээлч сэтгэлгээний дундаж үзүүлэлтүүдийг харьцуулахад туршилтын бүлгийн дундаж оноо ( $M = 3.10$ ,  $SD = 0.42$ ) хяналтын бүлгийн оноо ( $M = 2.76$ ,  $SD = 0.37$ ) – оос өндөр байна. STEM боловсролд суурилсан туршилтын хичээл сурагчдын бүтээлч сэтгэлгээний чадваруудыг хөгжүүлж байна.

**Түлхүүр үг:** ЕБС-ийн сурагчид, Бүтээлч сэтгэлгээ, STEM сургалтын хэрэглэгдэхүүн, Туршилт хичээл, Алхам алхмаар бие даах аргазүй

## Цэргийн болон хууль сахиулах байгууллагын их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан туршилтад суурилсан физик сургалтын арга

Б.Солонго, ҮБХИС Х.Түвшин-Эрдэнэ, ДХИС Г.Мягмарсүрэн, доктор ҮБХИС

**Хураангуй:** Энэхүү судалгаанд туршилтад суурилсан сургалтын арга нь физикийн суурь ойлголт сул их, дээд сургуулийн 1-р курсын оюутнуудын ойлголт болон сурлагын амжилтад үзүүлэх нөлөөг судлав. Судалгаанд Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль болон Дотоод Хэргийн Их Сургуулийн оюутнуудын шалгалтын өмнөх ба дараах онооны дундаж, стандарт хазайлт, статистикийн шалгалтын хариуг авч үнэлсэн. Үр дүнгээс харахад сургалтын дараах оноо статистикийн ач холбогдолтойгоор нэмэгдсэн ( $p < 0.05$ ) бөгөөд туршилтад суурилсан сургалт нь сул гүйцэтгэлтэй оюутнуудын ахицыг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн ялгааг бууруулах нөхөх нөлөө үзүүлсэн бол өндөр гүйцэтгэлтэй оюутнуудын хувьд үнэлгээний дээд хязгаарын нөлөө ажиглагдсан.

**Түлхүүр үг:** туршилтад суурилсан сургалт, физикийн боловсрол, суралцах ахиц, гүйцэтгэлийн ялгаа, нөхөх нөлөө

## Оюутан багшийн химийн хэлний кодлох, декодлох чадварын судалгаа

Б.Норовсүрэн, доктор МУБИС

**Хураангуй:** Шинжлэх ухааны ойлголтуудын талаарх гүнзгий мэдлэгийг хөгжүүлэх гол түлхүүр бол тухайн шинжлэх ухааны хэлийг ашиглах, ойлгох явдал юм. Тиймээс химийг ойлгох, аливаа ойлголт, ухагдахууныг хэрэглэхэд химийн тэмдэг, тэмдэглэгээний цогц болох семиотик системийг эзэмшсэн байх шаардлагатай байна. Химийн хэлийг эзэмшинэ гэдэг нь зөвхөн тэмдэглэгээг цээжлэх биш, харин түүгээр дамжуулан молекул ертөнцийг 'уншиж' сурах үйл явц юм. Тиймээс судлаачид "оюутан химийн бодлого бодож чадах" эсэхээс илүүтэй химийн хэлийг уншиж чадаж байгаа эсэхийг судлахад гол анхаарлаа хандуулж байна. Энэхүү илтгэлээр МУБИС-ийн Химийн багшийн ангийн оюутнуудын химийн тэмдэг, тэмдэглэгээг хэрэглэх, уншиж ойлгох чадварын түвшинг илрүүлсэн үр дүнг танилцуулна. Химийн тэмдэг, тэмдэглэгээний агуулгын хүрээ, түүнд нийцсэн шалгуурын дагуу боловсруулсан үнэлгээний хэрэгслээр өгөгдлийг цуглуулсан. Өгөгдөлд IBM SPSS statistics программ ашиглан дескриптив анализ, хувьсагч хоорондын хамаарал, ANOVA шинжилгээ зэргийг хийсэн. Судалгааны үр дүнд химийн элементийн тухай чадварын дундаж гүйцэтгэл 59.13%, химийн томъёоных 54.6%, урвалын тэгшитгэлийнх 63.25% тус тус байгаа мөн стандарт хазайлт 20-оос дээш байгаа нь оюутнуудын гүйцэтгэл тогтворгүй химийн тэмдэг, тэмдэглэгээг хэрэглэх, уншиж ойлгох чадвар хангалтгүй түвшинд эзэмшсэн байгааг харуулж байна. Энэ нь химийн тэмдэг, тэмдэглэгээний тухай агуулга, арга зүйн асуудлыг нарийвчлан судлах шаардлагатайг илтгэж байна.

**Түлхүүр үг:** Химийн хэл, химийн тэмдэглэгээ, кодлох, декодлох чадвар

## Сургуулийн өмнөх боловсролын сургалтын төсөлд суурилсан арга зүй, судалгаа

Б.Даариймаа, Говь-Алтай Б.Жавзандулам, МУБИС

**Хураангуй:** Энэхүү судалгаа нь эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагаагаар төсөлд суурилсан арга зүйгээр дамжуулан бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг монгол ахуйтай танилцуулах туршилт, үйл ажиллагааны үр дүнг тооцоход чиглэсэн ба ажиглалт, туршилтын аргыг ашиглан бэлтгэл бүлгийн хүүхдүүдээс төсөлд суурилсан арга зүйг хэрэгжүүлэхийн өмнөх ба хэрэгжүүлсний дараах судалгааг авсан. Мөн асуулгын аргаар тус төсөлд суурилсан арга зүйг хэрэгжүүлэхэд эцэг эхийн оролцоо дэмжлэгийг илрүүлэх судалгаа авсан. Ажиглалт, туршилтын судалгааны үр дүнд хүүхдийг монгол ахуйтай танилцуулах үйл ажиллагааны үр дүн ахиц их, хүүхэд монгол ахуйгаас суралцахдаа баяр баясгалантай, өөртөө итгэлтэй, суралцах хүсэл тэмүүлэлтэйгээр өв соёл, хийсэн зүйлээрээ бахархаж байгаа нь ажиглагдсан. Эцэг эх асран хамгаалагчдаас авсан судалгааны дүнгээс харахад хүүхдийг багаас нь монгол ахуйтай танилцуулж, суралцуулах нь олон талын ач холбогдолтой хэмээн дүгнэж багшийн чиглүүлэг сайн байвал эцэг эхчүүд бүлгийн үйл ажиллагааг дэмжин оролцох боломжтой хэмээн үзжээ. Эндээс харахад төсөлд суурилсан арга зүйг хэрэгжүүлэхэд эцэг эхийн оролцоо дэмжлэг маш чухал бөгөөд багшийн үр чадвар, хэрхэн чиглүүлэхээс шалтгаалахаар байна.

## Цэцэрлэгийн нэгдмэл сургалтын төлөвлөлтөд хийсэн дүн шинжилгээ

Дэд профессор Ц.Наранцэцэг Магистр М.Маралмаа

**Хураангуй:** Монгол улсад шинэчлэн батлагдсан Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр нь хүүхдийн хөгжлийн үндсэн чиглэлд уялдаа холбоотой, цогц байдлаар төлөвлөн хэрэгжүүлэх зарчмыг баримталж, сургалтын орчныг хүүхдэд ээлтэй, идэвхтэй оролцоонд суурилсан байдлаар нэгдмэл төлөвлөхийн чухлыг тусгасан. Хүүхдийн хөгжлийн талаар дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн онолуудад хөгжлийн үйл явц нь салангид биш, харин турших, тоглох, орчинтой харилцах олон талт цогц үйл явцын нэгдэл болохыг тодорхойлсон байдаг. Монгол улсад 2025-2026 оноос хэрэгжиж эхэлсэн шинэ сургалтын хөтөлбөрт "хүүхдийн хөгжлийн үнэлгээг олон талт оролцоонд тулгуурлаж, сургалтын төлөвлөлттэй нягт уялдуулна" гэж заасан нь багшийн боловсруулж буй нэгдмэл төлөвлөлтийн чанар,

шүтэлцээний түвшинг мэргэжлийн түвшинд үнэлэх механизм шаардлагатайг харуулж байна. Нэгдмэл сургалтын төлөвлөлтийн чанарыг үнэлэх арга зүй боловсруулах, бодит хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх нь СӨБ-ын сургалтын чанарыг сайжруулахад чухал нөлөө үзүүлнэ. Бид энэхүү судалгаагаар Баянхонгор аймаг болон Улаанбаатар хотын нийт 30 бүлгийн багш, 30 цэцэрлэгийн төлөвлөлтийн баримт бичгийг судлан, нэгдмэл сургалтын төлөвлөлтийг багш нар хэрхэн ойлгож үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байгааг харьцуулан судалж, үр дүнг нь танилцуулж байна.

**Түлхүүр үгс:** Нэгдмэл сургалтын арга зүй, нэгдмэл төлөвлөлт, бага насны хүүхдийн цогц хөгжил, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр, үнэлгээ

### **Физикийн е-лаборатори бүтээхэд VR технологи ашиглах нь /Фотоцахилгааны үзэгдлийн жишээн дээр/**

Т.Уламбаяр, МУБИС П.Энхцэцэг, ХААИС О.Лхагва, МУИС

Орчин үеийн физик сургалтанд мэдээлллийн технологийн шинэ ололт нээлтүүдийг нэвтрүүлэн хэрэглэх нь зайлшгүй шаардлага бий болоод байна. Мөн байгалийн ухааны хичээлийг сонгон суралцах суралцагчдын тоо цөөрсөн талаар сүүлийн хэдэн жил яригдаж бодлого болон хэрэгжиж байгаа ч тодорхой үр дүн гарахгүй байгаа нь үнэн.

Энэ асуудлыг шийдвэрлэх нэг үндсэн арга бол тухайн шинжлэх ухааныг сонирхолтой орчин үеийн технологитой хослуулан хэрэглэх нь давуу талтай байна. Иймээс физик сургалтанд VR технологийг хэрэглэн туршилт хичээл хийх нь орчин үеийн сурагчдын хувьд суралцах идэвхи нэмэгдэх, физик судлагдахууныг сонирхон судлах суралцагчид нэмэгдэх боломжийг бий болгоно.

Энэхүү ажилд фотоэффектийн үзэгдлийн VR лабораторийг анхлан боловсруулан танилцуулж байна. Энэхүү лабораторийн ажил нь web болон VR хэлбэрээр ажиллана. Фотоэффектитийн үзэгдлийн дотоод процессийг сурагцагчид өөрснөө нүдээр харж гараар ажиллахаар тухайн суралцагчдын сонирхол болоод мэдлэг бүтээл үйл идэвхжинэ.

VR хэлбэрт оруулан суралцагчид тухайн физик үзэгдлийг судална. Уг ажилд физикийн үндсэн тогтмолуудын нэг болох Планкын тогтмолыг тодорхойлно. Мөн металлын шинж чанараас хамаарах гарахын ажил, улаан хилийн давтамж, улаан 36 хилийн долгионы уртыг судлана. Цаашилбал электроны масс, фотоны энерги гэх мэтээр өргөжүүлэн хэрэглэж болно.

### **Багшийн хөгжил ба эрүүл мэндийн тулгамдсан асуудал**

М.Дашпүрэв, МУИС Т. Дуламрагчаа, МУБИС

**Хураангуй:** Энэхүү судалгаагаар багшийн хөгжил ба эрүүл мэндийн асуудлыг тодорхойлох зорилгоор асуулга судалгааг явуулж, бусад судлаачийн үр дүн болон олон улсын судалгааны чиг хандлагатай харьцуулсан. Асуулгад баруун, зүүн, төвийн бүс болон нийслэл хотын ЕБС-ийн 206 (эрэгтэй 24, эмэгтэй 182) багш санамсаргүй түүврээр хамрагдсан бөгөөд бага ангийн багш 71,8% (148), дунд ангийн багш 14,6% (30), ахлах ангийн багш 13,6% (28) байв. Багшийн хөгжил ба эрүүл мэндийг судалсан WoS-ын 9160 өгүүллээс олон улсын судалгааны чиг хандлагыг тогтооходоо VOSviewer ашиглав. Асуулгын үр дүнгээс үзэхэд багш нарын дийлэнх нь ажлын ачаалал их, зав чөлөө муу байдгаас үүдэн эрүүл мэндийн асуудалд өртөх эрсдэл өндөр байна. Ялангуяа хараа муудах, нуруу, зүрх өвдөх, ядрах, сэтгэлзүйн стресс зэрэг асуудлууд зонхилж байна. Багшийн ажил хүнд гэж 85,4% нь, багшлах ажил эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна гэж 64,9%, багшлах ажил стресс их үүсгэдэг гэж 70,6% нь, багшийн хөгжилд эрүүл мэнд чухал гэж 57,8% нь хариулсан байна. Энэ нь Монгол улсад 20 жилийн өмнө хийгдсэн зарим судалгааны үр дүнтэй ойролцоо байв. Иймд багшийн эрүүл мэнд нь багшид тулгамдаж буй асуудал хэвээр байна. Олон улсын судалгааны кластраас харахад багшийн хөгжлийг боловсруулсан бодлоготой холбон судалж байсан бол одоо багшийн сэтгэл зүй, багшлах ажлын үр дүнтэй холбон түлхүү судалж байна. Багшийн хөгжил нь зөвхөн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх асуудлаар хязгаарлагдахгүй, харин багшийн эрүүл мэнд, бие бялдар, сэтгэлзүй, нийгмийн сайн сайхан байдлыг хамарсан цогц бодлогоор дэмжигдэх шаардлагатай байна.

**Түлхүүр үг:** Багшийн хөгжил, эрүүл мэнд, стресс, ажлын ачаалал, боловсролын чанар

## **Өсвөр насны хүүхдүүдийн эцэг эхийн хүмүүжүүлэх хэв маяг, үе тэнгийн дээрэлхэлт, сэтгэл хөдлөлийн зохицуулалтын нөлөөг судалсан нь**

Э.Ану, Х.Сэндмаа

**Хураангуй:** Өсвөр насныхны зан үйл, сэтгэл хөдлөлд бие хүний онцлогоос гадна гэр бүлийн орчин, үе тэнгийн харилцаа зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Үе тэнгийн дээрэлхэлт нь өсвөр насанд түгээмэл тохиолддог нийгмийн асуудал бөгөөд сэтгэл гутрал, түгшүүр, ганцаардал, өөрийн үнэлэмж буурах зэрэг сөрөг үр дагавартай Энэхүү судалгаанд өсвөр насны хүүхдүүдийн эцэг эхийн хүмүүжүүлэх хэв маяг, сэтгэл хөдлөлийн зохицуулалт, үе тэнгийн дээрэлхэлт хоорондын хамаарлыг судалсан. Судалгаанд 11-18 насны 362 оролцогчийг хамруулсан бөгөөд өсвөр насныхны үе тэнгийн дээрэлхэлтийг хэмжих түрэмгийлэл болон хохирлын хэмжүүрийн асуулга (AS & VS), эцэг эхийн хүмүүжүүлэх хэв маягийн асуулга (PSDQ), сэтгэл хөдлөлийн зохицуулалтын асуулга (ERQ) -уудыг ашиглаж, өгөгдлийг SPSS программ ашиглан боловсруулав. Судалгааны үр дүнд эцэг эхийн ардчилсан болон захирангуй хүмүүжүүлэх хэв маяг нь сэтгэл хөдлөлийн зохицуулалттай хамааралтай гарсан. Мөн түрэмгийллийн түвшин айлын бага болон өрхийн орлого доогуур байгаа хүүхдүүдэд илүү өндөр байсан.

**Түлхүүр үг:** Өсвөр нас, эцэг эхийн хүмүүжүүлэх хэв маяг, үе тэнгийн дээрэлхэлт, сэтгэл хөдлөлийн зохицуулалт

### **Сургуулийн хөгжлийг дэмжих менежментийн нэгэн загвар**

Ж.Галбадрах, УИХ

Энэхүү өгүүлэл нь Монгол улсын ерөнхий боловсролын сургуулиудын засаглал, менежментийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг "Шинэ Монгол" сургуулийн 20 жилийн туршлага болон төрийн өмчийн сургуулиуд дээр хэрэгжүүлсэн "Сургуулийн менежментийг сайжруулах" төслийн үр дүнд үндэслэн нэгтгэсэн. Төрийн өмчийн сургуулиудын хувьд дотоод нөөц, боломжинд тулгуурласан "Сургуулийн хөгжлийг дэмжих менежментийн загвар (School Development Management Model: SDMM)" -ыг боловсруулж, хэрэгжих нөхцөл, үр нөлөөг практик туршилтаар харуулахыг зорьсон болно.

Судалгаагаар сургуулийн хөгжил нь зөвхөн санхүүжилтээс хамаарах бус, нэгдмэл зорилго, алсын хараагаа байгууллагаараа хамтран батласан эсэх, байгууллагын соёл, дунд шатны удирдлагын манлайлал, багш нарын хамтын ажиллагааг "багт нэгтгэсэн" эсэхээс хамааралтай болохыг нотолж, менежментийн энэхүү нэгдсэн загварыг гаргасан.

### **Боловсролын шинэчлэлийн хүрээнд эцэг эх сургуулийн хамтын оролцооны туршилтын загвар боловсруулах нь**

Ц.Галбадрах, Шинэ санаа ЕБС

**Хураангуй:** Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын боловсролын шинэчлэлийн хүрээнд эцэг эхийн оролцооны өнөөгийн байдал, түүнээс үүдэлтэй хүүхдийн суралцах идэвх, зан төлөв, суралцах үр дүнгийн ялгааг тодорхойлж, боловсролын шинэчлэлд тулгуурласан хамтын оролцооны загварыг боловсронгуй болгоход оршино. Судалгаанд "Шинэ санаа" сургуулийн 10–12-р ангийн 43 эцэг эхийг хамарсан анкет, 10 эцэг эхтэй фокус бүлгийн ярилцлага, 43 хүүхдийн 4 долоо хоногийн ажиглалт ашиглан холимог арга зүй хэрэглэв. Судалгааны үр дүнгээс харахад:

- Эцэг эхийн гэрт үзүүлж буй дэмжлэг өндөр /4.5/ боловч сургуулийн үйл ажиллагаанд оролцох түвшин доогуур /3.1/ байна.
- Эцэг эхийн оролцоо нь хүүхдийн суралцах идэвх, сахилга, зан төлөвт шууд эерэг хамааралтай бөгөөд оролцооны чанарын ялгаа нь суралцах үр дүнд ялгааг үүсгэдэг.

- Олон улсын туршлага (Япон, Финланд, Сингапур) нь эцэг эхийн оролцоог идэвхжүүлэх гол хүчин зүйлсийг: Мэдээллийн ил тод байдал, гэрт дэмжлэг үзүүлэх систем, сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломж, хамтын шийдвэр гаргах механизм гэж тодорхойлсон.

Эдгээр үндэслэлээр боловсруулсан эцэг эх–сургууль хамтын оролцооны загвар нь хүүхдийн суралцах идэвх, сахилга, зан төлөвийг дэмжих, сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, боловсролын шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг харуулж байна.

## **Биологийн элсэлтийн шалгалтын даалгаврын шинжилгээ (2021-2025)**

Д.Чинзориг

**Хураангуй:** Суралцагчдын суралцахуйн талаарх мэдээлэл цуглуулахдаа хэрэглэдэг бүхий л үйл явц, мөн суралцахуйтай холбоотой тоон дүгнэлт бүрдүүлэлтийг багтаасан ойлголт юм. Одоогийн хэлбэрээр тогтмол зохион байгуулагдаж буй их сургуулийн элсэлтийн уралдаант шалгалтыг анх Монгол Улсын хэмжээнд Боловсролын үнэлгээний төв (БҮТ) 2006 оноос эхлэн жил бүр зохион байгуулж байна. Элсэлтийн шалгалт (хуучнаар, элсэлтийн ерөнхий шалгалт)-ийн сэдэв даалгавруудыг тухайн хичээлүүдийн хөтөлбөрийн агуулгын хүрээнд тохирсон, шалгуулагчийн мэдлэг, танин мэдэхүйн түвшин, сурах ерөнхий чадварыг шалгахаар боловсруулагдсан сорилгын (тестийн) хэлбэртэй байна. Элсэлтийн шалгалтын даалгавар гүйцэтгэх хугацаа нь хичээлийн онцлогоос хамааран 80 болон 100 минут байна. Гэтэл биологийн элсэлтийн шалгалт нь байгалийн ухааны хичээлийн багцад хамаарагдах боловч нийгмийн ухааны хичээлүүдийн адил 80 минут хэвээр байгаа төдийгүй хоёрдугаар хэсгийн даалгаврууд олон жил харгалзуулах хэлбэрээр боловсруулагдаж ирсэн. Харин сүүлийн жилүүдэд шинжлэх ухааны хичээл гэдэг утгаараа Биологийн элсэлтийн шалгалтын хоёрдугаар хэсэгт задлан шинжлэх, тооцох даалгаврууд нэмэгдэж математик чадварыг биологийн жишээн дээр шалгаж байгаа нь сайшаалтай байна. Баримт бичгийг судлах аргазүйгээр биологийн хичээлийн 2021-2025 онуудын элсэлтийн шалгалтын үр дүнгийн тайланг ашиглан боловсруулалт хийсэн. Энэхүү илтгэлийн хүрээнд дээрх онуудад зохион байгуулагдсан Биологийн элсэлтийн шалгалтын даалгавар тус бүрийн хүндрэлийн зэрэг (difficulty index), ялгах чадвар (discrimination index)-ийн мэдээллийг ашиглан олон улсын биологийн хөтөлбөрүүдийн агуулгуудын дагуу ангилан агуулгын гүйцэтгэлд шинжилгээ хийж үзэв.

**Түлхүүр үгс:** Биологийн элсэлтийн шалгалт, даалгаврын шинжилгээ, хүндрэлийн зэрэг, ялгах чадвар

### **“Нийслэлийн 12-р ангийн сурагчдын химийн мэдлэгийн түвшний оношлогоо ба ЭЕШ-д бэлтгэхэд анхаарах агуулгын шинжилгээ”**

Ө.Мөнхтуяа, М.Пүрэвдагва, Э.Мэндсайхан

Энэхүү судалгааны зорилго нь нийслэлийн 12-р ангийн сурагчдын химийн хичээлийн мэдлэгийн түвшинг оношлох, ЭЕШ-д бэлтгэхэд анхаарах шаардлагатай агуулгыг тодорхойлоход оршино. Судалгаанд нийслэлийн 9 дүүргийн нийт 1541 сурагч хамрагдсан бөгөөд 100 минутын хугацаатай, 40 тест (68 оноо), 4 задгай даалгавар (32 оноо)-оос бүрдсэн шалгалтыг блюпринтийн дагуу зохион байгуулсан. Агуулгын 90%-ийг 10–11 дүгээр ангийн заавал судлах хөтөлбөрөөс сонгожээ. Судалгааны дүнгээр шалгалтын дундаж гүйцэтгэл 34.39%, медиан оноо 31 байсан нь өмнөх оны үзүүлэлттэй ойролцоо түвшинд байна. Дүүргүүдээс Сүхбаатар дүүрэг (39.1%) хамгийн өндөр, харин Хан-Уул дүүрэг (31.08%) хамгийн бага гүйцэтгэлтэй байв. Агуулгын хувьд ерөнхий химийн мэдлэг (41.28%) харьцангуй сайн, харин физик химийн гүйцэтгэл (31.17%) хамгийн сул үзүүлэлттэй байна.

Сурагчид химийн тэнцвэр, термодинамик (энтальпийн өөрчлөлт), химийн кинетикийн тооцоот бодлого, мөн органик химийн орон зайн изомер (цис-транс) болон функциональ бүлэгт суурилсан нэршлийн даалгаварт хүндрэлтэй байгааг илрүүлэв.

Иймд сурагчдын суурь мэдлэг тогтвортой хэдий ч тооцоот болон аналитик чадварыг хөгжүүлэх шаардлагатай байна. Цаашид ЭЕШ-д бэлтгэхдээ химийн тэнцвэр, термодинамик, энергийн өөрчлөлтийн агуулгыг гүнзгийрүүлэн бататгаж, бодлого бодох арга зүйг сайжруулахад түлхүү анхаарах нь зүйтэй.

## **Developing an assessment instrument to measure primary teachers' mathematical knowledge for teaching**

Г.Пүрэвчулуун

At the international level, extensive research has been conducted on the development of assessment tools and tasks aimed at evaluating and enhancing Mathematical Knowledge for Teaching (MKT). In Mongolia, however, standardized assessment tasks designed to measure the professional knowledge required for primary school teachers to effectively teach mathematics, as well as to support their professional development through self-assessment, have not yet been developed or implemented.

This study develops assessment tasks and criteria for evaluating primary school teachers' MKT within the framework of the MKT theoretical model, grounded in Marzano's Taxonomy. Furthermore, the study compares the assessment results with teachers' self evaluations. Data were collected from 77 primary school teachers from 7 secondary schools in Khovd province between June 7 and 14, 2024. The results show that the correlation coefficients among the six domains of MKT range from 0.254 to 0.629.

The knowledge of content and teaching domain shows weak correlations with common content knowledge ( $r = 0.391$ ) and horizon content knowledge ( $r = 0.254$ ), whereas specialized content knowledge and knowledge of content and curriculum demonstrate a positive, moderate correlation ( $r = 0.639$ ).

## **Байгалийн ухааны элсэлтийн шалгалтыг амжилттай өгсөн шалгуулагчдын Их, дээд сургуульд элсэх тэгш боломж**

Д.Цэцэгдэлгэр, Т.Отгон-Эрдэнэ Д.Энхжаргал

**Хураангуй:** Энэхүү судалгаагаар Монгол хэл, бичгийн шалгалтын сүүлийн дөрвөн жилийн өгөгдөлд тулгуурлан босго даваагүй буюу 400-аас доош оноо авсан шалгуулагчдын хүйсийн ялгаа болон тэдний байгалийн ухааны хичээлийн гүйцэтгэл дэх хамаарлыг шинжиллээ. Үр дүнгээс харахад эмэгтэй шалгуулагчид Монгол хэл, бичгийн шалгалтад эрэгтэйчүүдээс тогтмол өндөр гүйцэтгэлтэй байсан бөгөөд босго оноо даваагүй шалгуулагчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдээс 1.5–2 дахин өндөр байна. Мөн уг бүлгийн шалгуулагчид математик, физикийн хичээлүүдэд харьцангуй өндөр гүйцэтгэл үзүүлэх хандлага ажиглагдсан бол хими, биологийн хичээлийн хувьд хүйсийн ялгаа статистикийн хувьд ач холбогдол багатай байна. Дүгнэж үзэхэд, Монгол хэл, бичгийн шалгалтын босго оноо нь байгалийн ухаанд чадвартай зарим шалгуулагчдын дээд боловсрол эзэмших боломжид нөлөөлж болзошгүй тул энэхүү асуудлын шалтгааныг цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.

## **Төгсөгчдийн ур чадварт чадамжид тулгуурласан сургалт нөлөөлөх нь**

Ж.Эрдэнэзаяа, Н. Ариунаа

**Хураангуй:** Орчин үед ажил олгогчид ажлын байранд шаардлагатай ур чадварыг эзэмшсэн төгсөгчдийг илүүтэй сонирхох болсон. Иймд энэхүү судалгаагаар 19 ажил олгогчоос төгсөгчдийн зөөлөн ур чадвар, суурь шинжлэх ухааны мэдлэг, мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг тодорхойлж, 120 төгсөгчөөс ажил олгогчдын шаардлагад нийцэж буй эсэхийг үнэлсэн. Мөн МУИС-ийн Бизнес, Мэдээллийн Технологийн Сургуулийн сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн чадамжид суурилсан сургалтын үр дүнг нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн хүрээнд нэгтгэн дүгнэв. Судалгааны үр дүнгээс харахад чадамжид суурилсан сургалтыг хэрэгжүүлснээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин сүүлийн гурван жилийн дунджаар 86.2%-д хүрч өссөн байна. Түүнчлэн ажил олгогчдын үнэлгээ өмнөх хоёр жилтэй харьцуулахад 5.21%-иар, төгсөгчдийн өөрийн үнэлгээ 2.79%-иар тус тус нэмэгдсэн байна. Эдгээр үзүүлэлт нь чадамжид суурилсан сургалт нь төгсөгчдийн ур чадвар, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байгааг харуулж байна.

**Түлхүүр үг:** Боловсрол, чадамж, сургалтын орц, гарц, үр дүн, ахиц дэвшил

### **Дээд боловсролын байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийг CSI индексээр тооцох нь**

Ж.Эрдэнэзаяа Б.Долгорсүрэн

**Хураангуй:** Энэхүү судалгааны ажлаар дээд боловсролын байгууллагын хэрэглэгч болох оюутнуудын сэтгэл ханамжийг Customer Satisfaction Index (CSI) ашиглан хэмжих зорилго тавьсан. Судалгаанд МУИС-ийн Завхан сургуулийн төгсөгч болон суралцагч оюутнуудыг хамруулж, асуулгын аргаар өгөгдөл цуглуулсан. Сэтгэл ханамжид нөлөөлөх үндсэн хүчин зүйлс болох сургалтын орчин, багшлах боловсон хүчний мэдлэг чадвар, номын сангийн үйлчилгээ, сургуулийн хандлага зэрэг үзүүлэлтүүдийг ач холбогдол болон гүйцэтгэлийн үнэлгээгээр тодорхойлон CSI индексийг тооцсон. Судалгааны үр дүнд төгсөгчдийн CSI=7.46, суралцагчдын CSI=7.62 гарсан нь байгууллага хангалттай гүйцэтгэлтэй боловч сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Ялангуяа сургалтын орчин, материаллаг бааз болон номын сангийн үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэв. Энэхүү судалгаа нь дээд боловсролын байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах, хэрэглэгч төвтэй бодлого боловсруулахад ач холбогдолтой.

### **Их, дээд сургуулийн багшийн сэтгэл ханамжид хийсэн социологийн шинжилгээ**

Я.Отгонбаяр, Ц.Пионер

**Хураангуй:** Энэхүү судалгаагаар их, дээд сургуулийн багшийн ажлын сэтгэл ханамжийг

объектив болон субъектив хүчин зүйлсийн уялдаа холбооны хүрээнд шинжилж үнэлэхийг зорилоо. Судалгааг 2018 онд 750 багшаас, 2024 онд 450 багшаас тус тус онлайн хэлбэрээр, Уаанбаатар хот болон хөдөө орон нутгийн их, дээд сургуулийн төлөөллийг ханган явуулж, зарим үр дүнг харьцуулан шинжилсэн. Судалгааны хүрээнд багшийн ажлын сэтгэл ханамжид нөлөөлөх объектив хүчин зүйлсэд (цалин хөлс, ажлын ачаалал, ажлын орчин, байгууллагын дэмжлэг) болон субъектив хүчин зүйлсэд (хувийн үнэлэмж, мэргэжлийн бахархал, ажилдаа хандах хандлага, сэтгэл зүйн сэтгэл ханамж) дүн шинжилгээ хийсэн. Үр дүнгээс харахад багш нарын ажлын сэтгэл ханамж нь зөвхөн материаллаг нөхцөлөөс бус, харин хувь хүний дотоод үнэлэмж, мэргэжлийн утга учрыг мэдрэх байдалтай нягт уялдаатай болох нь тогтоогдсон. Мөн объектив нөхцөл хангалттай түвшинд бүрдээгүй тохиолдолд субъектив сэтгэл ханамж буурах хандлага ажиглагдсан бол эсрэгээрээ мэргэжлийн бахархал өндөр багш нар харьцангуй тааламжгүй нөхцөлд ч сэтгэл ханамжаа хадгалах хандлагатай байв. Судалгааны үр дүн нь багшийн хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, ажлын орчныг сайжруулах, мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх бодлогын хэрэгцээг харуулж байна.

**Түлхүүр үгс:** ажлын сэтгэл ханамж, их дээд сургуулийн багш, объектив хүчин зүйл, субъектив хүчин зүйл, боловсролын байгууллага

## **Ерөнхий хими II хичээлийн явцын шалгалтад давтан хэрэглэгдсэн даалгаврын чанарын гурван улирлын шинжилгээ**

Ш.Сайнбилэг, Ч.Нямгэрэл, Н.Амгалан, П.Манлайбаатар

**Хураангуй:** Энэхүү судалгааны зорилго нь Ерөнхий хими II (CHEM202) хичээлийн гурван

улирлын явцын шалгалтад давтан хэрэглэгдсэн сонгох хариултат даалгаврын чанарыг даалгаврын хүндрэлийн зэрэг, ялгах чадвар, буруу хариултын ажиллах байдлын үзүүлэлтээр үнэлж, улирал хоорондын өөрчлөлтийн хэв шинжийг тодорхойлоход оршино. Судалгаанд 2024–2025 оны намар, 2024–2025 оны хавар, 2025–2026 оны намрын улирлын өгөгдлийг ашиглаж, нийт 41 давтан хэрэглэгдсэн даалгаврыг шинжилсэн. Үүнээс өөрчлөлт дагуулсан 13 даалгаварт даалгаврын түвшний дагалдах хайгуул шинжилгээ хийв. Өгөгдөлд Фридманы шинжилгээ, Манн–Уитнигийн U тест, хараат бус бүлгийн t-шинжилгээ, хосолсон t-шинжилгээ, Вилкоксоны тэмдэгт зэрэглэлийн

шинжилгээ, Пирсоны  $\chi^2$  шинжилгээ, биномиаль ерөнхийшүүлсэн шугаман загвар хэрэглэв. Үр дүнгээс даалгаврын хүндрэлийн зэрэг гурван улирлын хооронд статистикийн хувьд ач холбогдолтой өөрчлөгдсөн бол ялгах чадвар сорилгын түвшинд харьцангуй тогтвортой байв. Харин 2024–2025 оны хавраас 2025–2026 оны намрын хооронд өөрчлөлт дагуулсан даалгавруудын ялгах чадвар өөрчлөлтгүй хэрэглэгдсэн даалгавраас илүү сайжирсан нь ажиглагдав. Даалгаврын түвшний шинжилгээ нь чанарын өөрчлөлт бүх даалгаварт ижил бус, харин даалгавар тус бүрийн онцлогоор илэрч байгааг харуулав. Иймээс олон сонголтот даалгаврын чанарыг үнэлэхдээ зөвхөн нэг удаагийн гүйцэтгэлийн үзүүлэлтээр хязгаарлахгүй, харин давтан хэрэглэгдсэн даалгаврын мөрдөлт, буруу хариултын шинжилгээ, даалгаврын түвшний нотолгоог хамтатган авч үзэх нь зүйтэй.

**Түлхүүр үг:** Ерөнхий хими II, Давтан хэрэглэгдсэн даалгавар, Даалгаврын хүндрэлийн зэрэг, Даалгаврын ялгах чадвар, Буруу хариултын ажиллах байдал, Хичээлд суурилсан үнэлгээ

## **Биеийн тамирын багшийн сургуулийн багийн тамирчдын аэроб чадварын судалгаа**

Д.Энхжин, МУБИС Д.Цолмонтуяа, доктор МУБИС Д.Анхбаяр, МУБИС

**Хураангуй:** Энэхүү судалгаагаар биеийн тамир, спортын чиглэлээр суралцагч оюутнуудын аэробик ажиллах чадварыг 20 метрийн shuttle run сорил, Borg 6–20 (RPE) шатлал болон өөрийн үнэлгээний асуулгаар үнэлэв. Үр дүнгээс shuttle run гүйцэтгэл болон өөрийн үнэлгээний хооронд дунд зэргийн эерэг хамаарал ( $r = .47, p < .05$ ), Borg үнэлгээ болон зүрхний цохилтын хооронд маш өндөр эерэг хамаарал ( $r = .95, p < .001$ ) илэрсэн. Асуулгын найдвартай байдал өндөр (Cronbach's  $\alpha = .82$ ) байв. Судалгааны үр дүн нь shuttle run сорилыг Borg шатлал болон өөрийн үнэлгээтэй хослуулан ашиглах нь оюутнуудын аэробик ажиллах чадвар, ачааллын субъектив мэдрэмжийг үнэлэхэд үр дүнтэй болохыг харууллаа.

**Түлхүүр үг:** Шаттл ран, Борг шалгуур, өөрийн үнэлгээ,

## **Бие даан суралцахуйн хүчин зүйлс сурагчдын математикийн амжилтад нөлөөлөх нь: PISA 2022 олон улсын үнэлгээний үр дүнгийн шинжилгээ**

Д.Цэцэгдэлгэр<sup>1</sup>, М.Бямбасүрэн<sup>2</sup>, Э.Цэрэнцоодол

**Хураангуй:** Энэхүү судалгаагаар "PISA 2022" олон улсын үнэлгээний үр дүнд үндэслэн сурагчдын бие даан суралцахуйн хүчин зүйлс математикийн амжилтад хэрхэн нөлөөлж буйг шинжлэн судаллаа. Судалгаанд математикийн өөртөө итгэх итгэл (MATHEFF), бүтээлч сэтгэлгээний өөртөө итгэх итгэл (CREATEFF), бие даан суралцах бэрхшээл (PROBSELF) болон гэр бүлийн дэмжлэг(FAMSUPSL) зэрэг хүчин зүйлсийг хамруулсан. Корреляци болон олон хүчин зүйлт регрессийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд математикийн өөртөө итгэх



итгэл нь сурагчдын амжилтад статистик ач холбогдол бүхий эерэг нөлөө үзүүлж байгаа бол бүтээлч сэтгэлгээний өөртөө итгэх итгэлийн нөлөө статистик ач холбогдол бүхий сөрөг хамааралтай. Ялангуяа сурагчдын нийгэм-эдийн засгийн үзүүлэлт (ESCS) нь математикийн оноог тодорхойлогч хамгийн хүчтэй хүчин зүйл болох нь тогтоогдлоо. Судалгааны үр дүн нь сурагчдын суралцах итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх, сургалтын тэгш бус байдлыг бууруулах замаар математикийн боловсролын чанарыг сайжруулах бодлогын зөвлөмж боловсруулахад ач холбогдолтой юм.

**Түлхүүр үг:** PISA үнэлгээ, Бие даан суралцахуйн хүчин зүйлс, Математикийн амжилт Математик өөртөө итгэх итгэл

### **Онлайн сургалтын үнэлгээний рубрикийн хөгжүүлэлт ба баталгаажуулалт**

Ц.Нямсүрэн, дэд проф. Л.Мөнхтуяа МУБИС

**Хураангуй:** Сүүлийн жилүүдэд онлайн сургалт дээд боловсролд түгээмэл хэрэглэгдэх болсон хэдий түүний чанарыг үнэлэх нэгдсэн ойлголт, баталгаажсан үнэлгээний хэрэгсэл хангалтгүй хэвээр байна. Иймээс энэхүү судалгааны зорилго нь онлайн сургалтын чанарыг үнэлэх рубрик боловсруулж, түүний найдвартай байдлыг шалгахад оршино. Судалгааны эхний шатанд онлайн сургалтыг үнэлэхэд түгээмэл хэрэглэгддэг олон улсын 11 хэрэгслийг баримт бичгийн шинжилгээний аргаар харьцуулж, тэдгээрийн нийтлэг болон ялгаатай шинжийг тодорхойлов. Харьцуулсан судалгааны үр дүнд тулгуурлан 6 шалгуур, 24 үзүүлэлт бүхий онлайн хичээлийн чанарын үнэлгээний рубрик боловсруулсан. Хоёр дахь шатанд боловсруулсан рубрикийг МУБИС-ын 20 онлайн хичээлд туршин үнэлгээ хийв. Үнэлэгч хоорондын найдвартай байдлыг *intraclass correlation coefficient (ICC(2,1))*, дотоод нийцлийг Cronbach-ийн альфа коэффициентээр тооцов. Судалгааны үр дүн нь онлайн сургалтын чанарыг үнэлэхэд ашиглах боломжтой рубрикийн загварыг санал болгож, цаашид илүү өргөн хүрээнд туршин сайжруулах шаардлагатай харуулж байна.

**Түлхүүр үг:** Онлайн сургалт, үнэлгээний хэрэгсэл, рубрик, найдвартай байдал, дээд боловсрол.

### **Цахимд суурилсан мэргэжлийн багш нарын бүлгээр байгууллагын менежментийг хөгжүүлэх нь**

Л.Адьяасүрэн

**Хураангуй:** Энэхүү судалгаагаар мэргэжлийн багш нарын бүлгээр багшлахуй болон суралцахуйд тулгамдсан асуудлыг илрүүлж, суралцагчдын суралцахуй, бие хүний ур чадварыг сургалт үйл ажиллагаагаар дэмжин хамтран ажиллах, харилцан суралцах нь багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих хамгийн бодитой дэмжлэг болно гэдгийг харуулахыг зорилоо. Багшийн хөгжлийн түлхүүр нь хамтын оролцоо ба эргэцүүлэлд суурилсан, тулгамдсан тухайн нэг асуудалд төвлөрч, шийдлийг хамтдаа эрэлхийлж, нээлттэй хэлэлцэж, шийдэлд хүрэх арга замыг боловсруулж, хэрэгжүүлэхэд оршино. Цахимд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлгийн зохион байгуулалтад шилжсэнээр багш мэргэжлийн бусад багш нартайгаа хамтран ажиллах, багшлахуйд тулгамдаж буй асуудлаа хамтран шийдвэрлэх, харилцан бие биеэ хөгжүүлэх, мэргэжлээрээ тасралтгүй ажиллах боломжтой болно.

**Түлхүүр үг:** цахимд суурилсан мэргэжлийн багш нарын бүлэг, хүний хөгжил, байгууллагын менежмент

## **Боловсролын давхраажилт, олон улсын оюутны шилжилт хөдөлгөөн, нийгмийн дахин үйлдвэрлэл: Япон дахь монгол оюутны суралцах замнал**

М.Ариунтуяа

This study examines the relationship between educational stratification, international student mobility, and social reproduction in Mongolia, focusing on Mongolian (former) students in Japan

Since the transition from a centrally planned to a market economy, study abroad patterns have shifted from state-funded mobility to diverse forms of privately financed mobility, including working while studying. This transformation reflects broader changes in both sending and receiving countries' policies. Drawing on Pierre Bourdieu's theory of cultural and social capital, this study conceptualizes education as a mechanism of social reproduction. Different school types in Mongolia contribute to unequal accumulation of capital, particularly in terms of language proficiency, academic preparation, and access to transnational networks, which in turn shape study abroad opportunities. Methodologically, the study employs a qualitative approach combining policy analysis, interviews, and focus group discussions. The findings reveal that study abroad pathways are not uniform but can be categorized into five distinct pathways: (1) linear or success pathway, (2) adaptive pathway, (3) detour pathway, (4) switching pathway, and (5) return pathways. The analysis demonstrates that while international student mobility is often framed as an opportunity for human capital development, it also reproduces social inequalities. The type of schooling significantly influences mobility opportunities, and even within similar structural conditions, individual pathways diverge depending on the interaction between structural constraints and personal agency. These findings suggest that international student mobility in Mongolia functions not only as a mechanism of mobility but also as a process of social stratification.

### **Их сургуулийн шинэ хичээл бүтээх үйлийн баримжаа,архитектур (“Боловсролын бизнесийн үндэс” хичээлийн жишээн дээр)**

Профессор Ц.Лувсандорж, доктор Ш.Жаргалсүрэн, доктор Ц.Пагмасүрэн,  
Г.Оюунсайхан, У.Алимаа МУБИС

**Хураангуй:** Багшид хөдөлмөрийн зах зээлд боловсролын бизнес хийх хэрэгцээ байна. Боловсролын салбарт ажиллагсдад 26 төрлийн боловсролын бизнесийн үйл ажиллагаанд оролцох, эзэмших боломжтой байдаг. Энэ хэрэгцээгээ хангахад шинжлэх ухааны үндэслэл шаардлагатай тул шинэ хичээлийг үүсгэх бодит шаардлага их, дээд сургуульд тулгарч байна.

Бизнесийн үндсэн ойлголтуудаас ялган, боловсролын бизнесийн жишээ, баримт, кейс, практик хэрэглээгээр баяжуулан, хичээлийн агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, хичээлийн стандарт, хөтөлбөр, сурах бичиг, лекц, семинарын материал зэрэг сургалтын төлөвлөгөөнд шаарддаг албан ёсны холбогдох бүх материал боловсруулсан 5 хичээлийн жилийн туршид хийсэн үйлийн судалгааны үр дүнд их сургуульд шинэ хичээл (course) бүтээх үйлийн баримжааг ялгаж, ерөнхий архитектурыг босгосон. Энэ нь судалгааны ажлын гол үр дүн болно. Энэхүү үйлийн баримжаа,архитектурын дагуу багшлах боловсон хүчний тасралтгүй суралцах үйл ажиллагааг зохион байгуулж хийсэн тэнхмийн их семинар, хөтөлбөрийн дэд хороо, салбар хороо, багш боловсролын салбар хороо гэх мэт бүх шатны хэлэлцүүлгээр сайшаан дэмжигдснээр МУБИС-д багш боловсролын сонгон судлах 2 кредитийн “Боловсролын бизнесийн үндэс” гэсэн шинэ хичээл албан ёсоор сургалтын төлөвлөгөөнд орсон болно.

## **Гэр бүлийн цагаар хүүхэдтэйгээ туршилт хийх талаарх судалгааны метадата шинжилсэн үр дүн**

Г.Эрдэнэцэцэг, доктор Ш.Жаргалсүрэн, доктор Ц.Пагмасүрэн,

**Хураангуй:** Гэртээ гэр бүлээрээ хялбар туршилт хийх чиглэлээр Web of science-ийн сэтгүүлд хэвлэгдсэн 603 өгүүллийн метадата ашиглан судаллаа. 2007 оноос судалгааны өгүүллүүд жилд 10-аас дээш тоотой бичигдэж эхэлсэн. Улс орнуудаас АНУ, Англи, Канад, Австрали, судалгааны байгууллагаас Пенсильвани мужийн Хамтын нөхөрлөлийн дээд боловсролын систем, судлаачаас Gerald J.Mahoney 11 судалгааны өгүүллээрээ тэргүүлж байна. ASEE ANNUAL CONFERENCE эрдэм шинжилгээний хурлын 3 эмхтгэл WoS-д бүртгүүлсэн. Сүүлийн жилүүдэд жилд 50 орчим өгүүлэл хэвлэгдэж байгаа нь харьцангуй шинэ судлагдахуун болж байна. Тогтвортой хөгжлийн зорилттой холбон авч үзвэл 284 өгүүлэл нь боловсролын чанар, 239 өгүүлэл нь эрүүл амьдралын хэв маягтай холбож бичигдсэн байна. Иймд гэр бүлийн цагаар хүүхэдтэйгээ туршилт хийх үйл ажиллагааны боловсролын чанар, эрүүл амьдралын хэв маягтай холбосон үр дүнг судалж болох, шинэ судлагдахуун байна.

## **Боловсролын дижиталчилал, хиймэл оюунчиллын тулгамдсан тулгуур 10 асуудал, шийдлийн үндэслэл, эргэцүүлэл**

Т.Лувсандорж, Л.Ганцэцэг, Г.Оюунсайхан, У.Алимаа

**Хураангуй:** Боловсролын бүхий л хэмжээсийн утга, үйл ажиллагааны бүхий л шинж чанар, агуулга, хэлбэрт хүчтэй, мэдрэгдэхүйцээр нөлөөлж буй дижитал хувьсгал, дижитал, дижиталчилал, виртуалчилал, дижитал шилжилт, дижитал хувиргалт, хиймэл оюунчилал нь биднийг боловсролын гүн ухаан, боловсролын сэтгэл судлал, боловсролын социологи, боловсролын хэмжилзүй, боловсролын дидактик, боловсролын технологи, боловсролын үнэлгээ, боловсролын бодлого, сургалтын аргазүй, дизайнаа эргэн харахад хүргэж байна. Боловсролын энэхүү хувьсгалт өөрчлөлт нь диконструктив шийдлийг шаардсан шинэ олон асуудал, хиймэл оюуны дидактик, хиймэл оюуны боловсролын гүн ухаан, боловсролын хиймэл оюуны гүн ухаан хиймэл оюуны боловсролын социологи, боловсролын хиймэл оюуны социологи гэх зэрэг олон шинэ ухагдахууныг үүсгэж байна. Энэхүү хэлэлцүүлэг илтгэлээр бид боловсролын дижиталчилал, хиймэл оюунчиллаас дэвшигдсэн тулгамдсан тулгуур 10 асуудлыг дэвшүүлж, түүний шийдлийн үндэслэл, үндэслэлийг эргэцүүллийг хуваалцах болно.

## **Өнөөгийн монголын боловсролын тулгамдсан социал асуудлууд, шийдвэрлэх арга зам**

Т.Санжбэгз

**Хураангуй:** Монголын боловсрол хямралт байдалтай байгаа бөгөөд хямралаас гарч чадахгүй байгаагийн шалтгаан нь зөвхөн төр, засгийн дэмжлэгтэйгээр боловсролын салбарынхны хүчинчармайлтаар даван туулах мэтээр ойлгож, хэрэгжүүлэхээр оролдож байгаа явдал юм. Хямралт байдлаас гарах арга зам бол боловсролыг социал харилцаа, социал институц, социал тогтолцоо болох талаас нь авч үзэн төр-боловсролын, үйлдвэрлэл-боловсролын, шинжлэх ухаан боловсролын, соёл-боловсролын, гэр бүл-боловсролын, хамт олон боловсролын парадигмуудад тулгуурлан төр, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, соёл, гэр бүл, боловсролын хамт олон, нийт ард түмний нэгдмэл зорилго, чиглэлтэй үйл ажиллагаа мөн гэсэн таамнал дэвшүүлж нотлохыг хичээсэн болно.

## **Харааны бэрхшээлтэй суралцагчтай харилцах математикийн сургалтын арга зүйн чанарын судалгаа**

Б.Сэрчмаа, Г.Оюунсайхан

**Хураангуй:** Энэхүү судалгааны ажил нь харааны бэрхшээлтэй суралцагчид математик заах арга зүйн одоогийн байдлыг чанарын судалгааны аргаар судалж, тулгарч буй бэрхшээл, шийдлийн арга замыг тодорхойлох зорилготой. Нийт 3 оролцогчтой гүнзгийрүүлсэн ярилцлага хийн, 6 хичээлийг ажиглаж, баримт бичгийн шинжилгээ хийсэн. Дөрвөн үндсэн сэдэв тодорхойлогдлоо: мэдрэхүйд суурилсан суралцах хэрэгцээ, туслах технологийн хязгаарлагдмал байдал, багшийн арга зүйн бэлэн бус байдал, нийгмийн оролцооны ач холбогдол. Бид цаашид тусгай хэрэгцээт боловсролыг дэмжиж сурагчдын суралцах эрхийг дэмжихэд хэрэгцээтэй судалгаа юм.

**Түлхүүр үг:** Чанарын судалгаа, харааны бэрхшээл, математикийн сургалт, тусгай хэрэгцээт боловсрол, тактиль арга, туслах технологи

## **Сонсголын бэрхшээлтэй сурагчдыг физикийн туршилтаар идэвхижүүлэх нь**

Т.Дүүрэнжаргал, Ө.Жавзмаа, МУБИС Удирдсан: Я.Мөнхсайхан МУБИС

**Хураангуй:** Орчин үеийн боловсролын чиг хандлагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургалтад тэгш хамруулах асуудал нэн чухал байна. Сонсголын бэрхшээлтэй сурагчдын хувьд мэдээлэл хүлээн авах үндсэн суваг нь харааны хүртэхүй байдаг тул физикийн хичээлээр дамжуулан шинжлэх ухаанч сэтгэлгээг төлөвшүүлэхэд уламжлалт заах арга барил (лекц, унших) хангалтгүй байна. Дэлхийн хүн амын 5% буюу 466 сая, Монгол улсад 115,000 орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаагийн дотор сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох тусгайлсан арга зүйг боловсруулах нийгмийн шаардлага тулгарч байна.

**Түлхүүр үг:** Сонсголын бэрхшээл, физикийн туршилт, суралцагчийн хандлага, регрессийн шинжилгээ, тэгш хамруулах боловсрол.

## **Мэргэжлийн боловсролын багшийн үүсгэгч хиймэл оюун ухааны талаарх мэдлэг, чадвар, хандлагыг судалсан судалгаа, үр дүн**

П.Отгонжаргал<sup>1</sup>, Л.Нарангарав<sup>1</sup>

<sup>1</sup>Техник технологийн их сургууль

**Хураангуй:** Сүүлийн үед Үүсгэгч Хиймэл Оюун Ухаан (ҮХОУ) болох ChatGPT, Google Gemini зэрэг хэрэгслүүд боловсролын салбарт, ялангуяа Мэргэжлийн Боловсрол, Сургалт (МБС)-ын хурдацтай өөрчлөгдөж буй орчинд томоохон нөлөө үзүүлж байна. Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь Монгол Улсын МБС-ын багш нарын ҮХОУ-ны талаарх онолын мэдлэг, сургалтын үйл ажиллагаанд ашиглах чадвар, мөн тус технологид хандах хандлагын өнөөгийн байдлыг цогцоор нь тодорхойлоход оршино. Судалгааг тоон арга зүйгээр гүйцэтгэж, МБС-ын байгууллага болон бусад салбарын 149 багшаас онлайн санал асуулгын аргаар мэдээлэл цуглуулсан. Цуглуулсан өгөгдөлд Дисперсийн болон Корреляцын шинжилгээг хийж, үндсэн хувьсагчдын хоорондын хамаарлыг тодорхойлов. Судалгааны үр дүнгээр багш нарын ҮХОУ-д хандах ерөнхий хандлага нь эерэг ( $M=3.5$ ) байгаа боловч, ҮХОУ-ны талаарх онолын мэдлэг ( $M=2.6$ ) болон бодит сургалтад ашиглах чадварын түвшин ( $M=2.41$ ) харьцангуй доогуур байгаа нь тогтоогдсон. Мөн багшийн мэдлэг болон хэрэглээний чадварын хооронд статистикийн ач холбогдолтой, эерэг хамаарал ( $r = 0.45$ ,  $p < 0.05$ ) байгаа нь батлагдсан. Судалгаагаар илэрсэн гол бэрхшээл нь ҮХОУ-ны ёс зүй, зохиогчийн эрхийн талаарх мэдээлэл болон сургалтын үйл ажиллагаандаа ашиглахуйц мэдлэгийн дутмаг байдал юм. Дүгнэлтээс харахад, МБС-ын багш нарын эерэг хандлага нь технологийн шинэчлэлд нээлттэй

байгааг илтгэж байгаа ч, мэдлэг болон чадварын түвшинг нэн даруй сайжруулах шаардлагатай байна. Иймд ҮХОУ-ны "Prompt Engineering" болон ёс зүйн хэрэглээнд чиглэсэн зорилтот сургалтуудыг яаралтай зохион байгуулах нь МБС-ын чанарыг дээшлүүлэх гол гарц болно.

**Түлхүүр үг:** Мэргэжлийн боловсрол, багшийн чадамж, мэдлэг, хандлага, prompt engineering.

### **Оюуны бэрхшээлтэй суралцагчийг бодит байдлын үнэлгээнд тулгуурлан суралцагчийг дэмжих, нийгэмд дасан зохицох чадварыг хөгжүүлэх аргазүйн асуудалд**

М.Насандулам, Удирдагч: Ц.Сумъяа доктор ТТИС

**Хураангуй:** Монгол улсын тогтвортой хөгжлийн бодлогын чиг хандлага нь суралцагчийн сурах хэрэгцээнд нийцүүлэн боловсролд тэгш хамрагдах, хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүн сурч, хөгжихөд ээлтэй тухтай орчныг бүрдүүлэхийг зорьж байгаа. Боловсрол тэгш хүртээмжтэй байна гэдэг нь суралцахуйн бүхий л үйл явцад тулгарах аливаа саад бэрхшээлийг тодорхойлж түүнийг арилгах замаар тэгш боломж бүрдсэн орчин нөхцөлд боловсрол эзэмших, суралцах үйл явцыг хэлнэ. Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх талаар "Алсын хараа 2050"-д тусгасан. Боловсролын багц хуулийн бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг үзүүлэх... гэж зааж өгсөн. Эдгээр хүмүүсийн нийгмийн оролцоог хангах, хүртээмжтэй дэд бүтэц, чанартай эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг бүрэн утгаар нь хүртэх нөхцөлийг хангах, хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой асуудлууд тулгарч байгаа нь судалгаагаар тогтоогджээ. 2023 оны статистикийн үндэсний хорооноос гаргасан мэдээгээр монгол улсад 111228 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт хүн амын 3 орчим хувийг эзэлж байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 10 орчим хувийг оюун ухааны бэрхшээлтэй иргэд эзэлдэг. Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн нийт суралцагчдын 80 орчим хувийг оюун ухааны бэрхшээлтэй иргэд эзэлж байгаа тул суралцах хэв маяг, хэрэгцээ, тэдний хөгжих хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх аргазүйн чиг хандлагыг тогтоох шаардлага урган гарч байна.

**Түлхүүр үг:** Оюуны бэрхшээл, Оюуны бэрхшээлтэй суралцагчийн Бодит байдлын үнэлгээ, Боловсролын тэгж хүртээмж

### **Химийн хичээлд суралцах сонирхол, хандлагын судалгаа**

Д.Лхагвадулам Удирдагч: Б.Норовсүрэн, доктор

**Хураангуй:** Орчин үеийн боловсролын чиг хандлага нь сурагчдад зөвхөн онолын мэдлэг олгохоос илүүтэйгээр тухайн мэдлэгийг амьдралд хэрэглэх чадварыг эзэмшүүлэхэд чиглэж байна. Олон улсын болон дотоодын судалгаанаас үзэхэд химийн шинжлэх ухаан нь сурагчдын хувьд хамгийн "хэцүү", "ойлгоход бэрх", "хийсвэр" хичээлүүдийн нэгд тооцогдсоор байна. Тиймээс химийн багш нар болон химийн боловсролын судлаачдын өмнө химийн хичээлд хандах хандлага, сонирхолыг судалж, түүний үр дүнг сургалтын ажилдаа хэрэглэх шаардлага алхам тутамд тулгарч байна. Энэхүү судалгаагаар ЕБС-ийн 6-12 дугаар ангийн 3089 сурагчийг хамарсан тэдний химийн хичээлд хандах хандлагын түвшин асуулгын аргаар илрүүлсэн судалгааны үр дүнг танилцуулж байна. Өгөгдөлд SPSS программ ашиглан дескриптив анализ, хувьсагч хоорондын хамаарал зэргийг хийсэн. Судалгааны үр дүнд химийн хичээлийн ерөнхий сонирхол сөрөг түвшинд (2.46), үүнээс бодлого бодох сонирхол (2.3) багатай, химийн хичээлийн ач холбогдлын үнэлэмж дундаж түвшинд (2.7), үүнээс химийн мэдлэгийн ахуй амьдрал дахь хэрэглээг сөрөг түвшинд (2.3), ирээдүйн ажил мэргэжил сонгох хэрэгцээг мөн сөрөг түвшинд (2.4) үнэлсэн байна. Химийн хичээлийн идэвх оролцоо дундаж түвшинд (2.6), үүнээс химийн аливаа асуудлыг бие даан судлах идэвх сөрөг түвшинд (2.28), төсөл хэрэгжүүлэх идэвх мөн сөрөг түвшинд (2.2) үнэлэгдсэн байна. Энэ бүгдээс ерөнхий боловсролын сургуулийн химийн хичээлийн агуулга нь амьдралаас тасархай, хийсвэр байдлаар

заагдсанаас шалтгаалан сурагчдын хичээлд хандах сонирхол буурах хандлагатай байгаа нь ажиглагдаж байна.

**Түлхүүр үг:** хандлага, сонирхол, химийн хичээлийн хандлага

**Харааны болон хөнгөн хэлбэрийн аутизмын бэрхшээлтэй сурагчдад физикийн хичээлийн туршилтыг үзүүлэх боломж /суурь боловсролын сурагчдын жишээн дээр/**

Г.Ганцэцэг Удирдагч багш Доктор С.Жамъян

**Хураангуй:** Хүмүүс мэдэрхүйн эрхтнүүдийн тусламжтайгаар мэдээллийг хүлээнд авдаг байна. Тэр тусмаа суралцах явцдаа мэдээллийн 75 орчим хувийг зөвхөн харах буюу нүдээр дамжуулан авдаг байна. Харин харааны бэрхшээлтэй сурагчдын хувьд энэ байдал өөр байдаг төдийгүй мэдээллийн ихэнх хувийг сонсох болон гар хурууны мэдэрхүйн тусламжтайгаар мэдээллийг авдаг байна. Иймээс физикийн хичээлийн туршилтыг энэхүү нөхцөл байдалд нь тохирсон хэлбэрээр явуулах нь үр дүнтэй болох талаар энэхүү судалгаандаа тусгасан болно. Мөн аутизм нь оюуны хам шинжийн бэрхшээл бөгөөд 1960-1970 онд 1:10000, 1980-1990 онд 1:1000, 2025 онд 1:100 болж нэмэгдсэн гэсэн ДЭМБ-с гаргасан судалгаа байна. Монгол улсад оюуны хам шинжийн бэрхшээлтэй сурагчид суралцдаг 4 тусгай сургууль байдаг бөгөөд тэдгээр нь хялбаршуулсан хөтөлбөрөөр суурь боловсролыг эзэмшүүлдэг. Эдгээр сургуульд физикийн хичээл ордоггүй ч хөнгөн хэлбэрийн аутизмтай сурагчид туршилтыг хийж магадгүй гэсэн таамаглалын үндсэн дээр туршилт судалгааг явуулсан. Монголд харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын эрхийг дэмжих тусгай сургууль байдаг бөгөөд Улаанбаатар хотод байрлах “Хараагүй хүүхдийн 116-р сургууль” энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Мөн зарим ердийн сургуульд тусгай хэрэгцээт боловсролын анги, орчин бүрдүүлэх талаар эрх зүйн баримт бичгүүдэд тусгасан байдаг. Харааны бэрхшээлтэй сурагчдад онолын мэдлэгийг хангалттай авах боломжтой байдагч туршилт хийх боломж маш хязгаарлагдмал байдаг. Иймд суралцахуйн удирдамжид тусгасан сэдвүүдээс харааны бэрхшээлтэй сурагчдаар туршилт хийлгэж болох сэдвүүд дээр туршилттай хичээл орж зарим үр дүнг гаргасан болно.

**Түлхүүр үг:** Харааны бэрхшээл, тусгай хэрэгцээт, физикийн туршилт, аутизм

**Эцэг эхийн зүгээс сургуулийн үйл ажиллагаанд оролцох байдлыг хэмжих асуулгын монгол хувилбарын найдвартай байдал**

Б.Отгонжаргал, О.Саранзул

Энэхүү судалгааны зорилго нь сурагчдын эцэг эх сургуулийн үйл ажиллагаанд оролцох байдлын хүүхдүүдээр дамжуулан судлах асуулгын хувилбар боловсруулж, түүний найдвартай байдал болон бүтцийн хүчинтэй байдлыг тогтоох явдал юм. Энд Мочо, Мартинс, Ратиньо, Нунес нарын боловсруулсан Португал улсын хувилбар (PSIQ-CV)-ын асуулгуудыг Монгол хэл рүү хөрвүүлэн, найруулгыг сайжруулан, Монголын нөхцөлд тохируулсан хувилбарыг ашиглалаа. Судалгаанд нийт Нийслэлийн Ерөнхий Боловсролын 24, 97-р сургуулийн 12-17 насны 452 сурагчийг хамрууллаа. Өгөгдлийн илрүүлэх хүчин зүйлийн шинжилгээ (EFA,  $n=141$ ) болон баталгаажуулах хүчин зүйлийн шинжилгээ (CFA,  $n=301$ ) гэж хоёр хэсэгт хуваан шинжлэсэн. EFA-ийн үр дүнд онолын загвартай хүчин зүйлийн бүтэц нь адил гурван хүчин зүйлд хамаарагдаж байна. Үүнд: (1) сургуулийн үйл ажиллагаанд оролцох ( $\alpha=0.79$ ), (2) гэрт суралцахад дэмжлэг үзүүлэх ( $\alpha=0.79$ ), (3) сургуультай харилцах, хянах ( $\alpha=0.71$ ) гарсан. CFA –ийн үр дүнгээр тухайн гурван хүчин зүйл нь бүтэц нийцлэлтэй болох нь батлагдсан (CFI=0.925, TLI=0.909, RMSEA=0.60 [0.048, 0.072], SRMR=0.046), энэ нь уг асуулгын Монгол хувилбар найдвартай хэмжилтийн хэрэгсэл болохыг харуулж байна.

## Сурагчдын ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн ээлжит хичээлийг төлөвлөж хэрэгжүүлэх арга зүйн туршилт (Газарзүйн хичээлийн жишээн дээр)

Г.Уранчимэг, А.Амгалан, Ш.Мипан

### Хураангуй

Энэхүү судалгааны зорилго нь сурагчдын суралцах хэв шинжийн ялгаанд тулгуурлан шинжлэн судлах арга барилыг газарзүйн ээлжит хичээлд ялгаатай суралцахуйтай уялдуулан хэрэгжүүлж, суралцах идэвх, гүйцэтгэлд үзүүлэх нөлөөг тодорхойлоход оршино. Судалгааны онолын үндэслэлд Нийл Флемингийн VARK загварыг ашиглан сурагчдын мэдээлэл хүлээн авах ялгаатай хэв шинжийг тодорхойлж, ялгаатай сургалтын арга зүйг төлөвлөсөн. 8 лугаар ангийн “Газар доорх ус”, “Агаарын даралт” сэдвийн хүрээнд шинжлэн судлах арга барилыг ялгаатай суралцахуйд тулгуурлан хэрэгжүүлэх төлөвлөж хийж хэрэгжүүлсэн болно.

Эмпирик судалгааг Улаанбаатар хотын ерөнхий боловсролын 1, 48 дугаар сургуулийн сурагчдын дунд явуулж, суралцах хэв шинжийг тодорхойлов. Үр дүнд нь сурагчдын дийлэнх нь үйл хөдөлгөөний (кинестетик) хэв шинж давамгайл байгааг тогтоож, сурагч бүрийн ялгаатай хэрэгцээ, онцлогийг харгалзан хичээлийг зохион байгуулсан. Бэлтгэл судалгааны шатанд авсан суурь мэдлэгийн үнэлгээгээр сурагчдын гүйцэтгэл 20 хувь байсан нь уламжлалт сургалтын арга хангалтгүй байгааг илтгэсэн.

Үүний дагуу шинжлэн судлах арга барилд суурилан, VARK загварт нийцсэн ялгаатай даалгавар, үйл ажиллагааг (ажиглах, хэлэлцэх, бичих, турших, бүтээх) хичээлд хэрэгжүүлсэн. Судалгааны үр дүнд сурагчдын гүйцэтгэл 80 хувьд хүрч, суралцах идэвх, оролцоо, асуудал шийдвэрлэх чадвар болон бие даан суралцах хандлага дээшилсэн байна. Иймээс шинжлэн судлах арга барилыг ялгаатай суралцахуйтай уялдуулан хэрэгжүүлэх нь сургалтын үр дүнг ахиулахад үр дүнтэй болохыг энэхүү судалгаа харуулж байна.

## Боловсролын удирдлагын философи, асуудал, шийдэл

Н.Пүрэвжав, Б.Батчимэг

**Хураангуй.** Боловсролын тогтолцоо нь хувь хүн, нийгэмд ялгаагүй өгөөжтэй, техник, технологийн шавхагдашгүй нөөцийг ашигласан товарлаг шинжтэй байвал зохино. Боловсролын функц бол хүний оршихуйн чадамжийг илэрхийлэх вектор хэмжигдэхүүн тул дараах хэлбэрээр томъёолж болно.

$$E(x,h)=\sum_{1-n}(x_{1-k})\times h$$

$E(x)$ - хувь хүний боловсорсон тухайн төлөв буюу боловсрол,  $F_{1-n}$ — боловсрох функцүүд буюу ухамсар, оюун, ухаан, сэтгэл, үнэ цэн, ёс зүй, соёл,  $x_{1-k}$ - боловсролын агуулга ерөнхий эрдэм гэхчилэн,  $h$ - дүгээр хувь хүний сурах өнцгийн итгэлцүүр.

Боловсролын чанар нь чадамж, боломжийн харьцаагаар тодорхойлогдоно.

$$Q(c_n)=P(c_n)/O(g_k)$$

$Q$ - боловсролын чанар,  $c_n$ -ндүгээр иргэн,  $P$ -чадамж,  $/$ - харьцаа,

$O$ -боломж,  $g_k$ -k дүгээр засаглал.

Хувь хүнд бүр зориулсан боловсролын зөвлөмж(бидний харж чадахгүй) бол хэрэглэгчийн авъяас сонирхол, бодит онцлогт төдийгүй ирээдүйн нөхцөл, байдалд нийцсэн эрсдэлгүй шийдэл, удирдлагыг хэрэгжүүлэх хүн бүрт чиглэсэн үйлчилгээ юм. Ингэснээр үйл ажиллагаа эрчимтэй, тасралтгүй, эрсдэлгүй, хүн бүрт хүртээлтэй байж гүйцэтгэлийг хянахад хялбар, жигд, хүртээмжтэй, шударга, алагчлалгүй болох юм. Боловсрох функц

хүнд заяагдмал учир боловсролын удирдлагын алсын хараа, цаашилбал багшийн эрхэм зорилго бол хүн бүрийн боловсрох функцүүд, өөрийн сэдэл- удирдлагыг хөгжүүлэх, түүгээр нь үнэлэх, улмаар бие дааж ажиллаж, амьдрахад сургах явдал болно.

Функциональ аксиологи боловсролын удирдлагын философи мөн.

№	Үйл ажиллагаа	Асуудал	Үр дагавар
1	Боловсрол	Хүний чадамж	Үр дүн
2	Боловсролын тогтолцоо	Чанар, хүртээмж	Үр ашиг
3	Боловсролын удирдлага	Чадамж, боломжийн нэгдэл	Үр өгөөж
4	Боловсролын удирдлагын ухаан	Объектив, субъектив боловсролын нийцэл	Үр нөлөө
5	Боловсролын удирдлагын философи	Чадамж, боломжийн нэгдмэл оршихуй	Үр шим
6	Боловсролын засаглал	Нийтийн сайн, сайхан	Үр бүтээл

Иймээс Монгол төрийн боловсролын удирдлагын үзэл баримтлал нь “Хүний өөрийн сэдэлд тулгуурласан, иргэний нийгмийн оролцоог дэмжсэн, нийтийн эрх ашигт суурилсан, мэргэжлийн, технологигжсон удирдлага хэрэгжүүлэх явдал” байх юм.

**Түлхүүр үг:** Боловсрол, түүний чанарын томъёо, удирдлагын философи, танхим-дигитал стандарт, сургалтын технологич багш.